НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны 12 дугаар сарын 11-ны өдөр

Багахангай дүүрэг

| Д/д | | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая төгрөг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь Үнэлгээ | Үнэлгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1ДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ (40 зорилт 130 арга хэмжээ)** | | | | | | | | | |
| **НЭГ. "КОВИД-19" ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО (1 зорилт 6 арга хэмжээ)** | | | | | | | | | |
| 1.1 | | **Зорилт-1.** Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 91 | Ариутгал халдваргүйжүүлэлт, худалдаа үйлчилгээний байгууллагуудын эрүүл ахуй, мэдээ мэдээллийн сувгуудаар урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хяналт тавин ажиллаж байна. | 100 | 100 |
| 1 | 1.1.1 | **Арга хэмжээ-1.1.1.** Нөхцөл байдлын мэдээллийг дүүргийн иргэдэд үнэн зөв, бодитой, нэг эх сурвалжаас хүргэх, коронавирус халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэнэ. | - | Мэдээллийн тоо Хандалтын тоо | Багахангай хэвлэл мэдээлэл болон холбогдох ААНБ-ын facebook хуудсаар 483 мэдээлэл, 35 видео контент бэлтгэн хүргэв. | Иргэдэд цаг үеийн холбоотой 80-аас доошгүй мэдээллийг хүргэсэн байна. | Коронавирусt халдварт цар тахлын өвчлөлийн дэгдэлтийг бууруулах зорилгоор иргэдэд нөхцөл байдлын мэдээг 10 удаа, зөвлөмжийг 24 удаа Эрүүл мэндийн төвийн цахим хаягаар тогтмол хүргэж ажилласан. | 100 | 100 |
| 2 | 1.1.2 | **Арга хэмжээ-1.1.2.** Худалдаа үйлчилгээний байгууллагуудын эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, халдваргүйжүүлэлтэд | - | Хяналт шалгалт зохион байгуулах тоо | 11 | 12 | Халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам", тусгай нөхцөл шаардлагыг хангах ажлын хүрээнд худалдаа үйлчилгээний байгууллагуудад 21 хоног тутамд халдваргүйжүүлэлт хийлгэн ажиллаж байна. Дүүргийн ЗДТГ-ын ТХҮХ нь дүүрэг дэх Мал эмнэлгийн тасаг, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Татварын улсын | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хяналт тавина. | | | | | байцаагч нартай хамтран тайлангийн хугацаанд нийт 10 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулав. | | |
| 3 | 1.1.3 | **Арга хэмжээ-1.1.3.** Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд халдваргүйтэл хийлгэх арга хэмжээг зохион байгуулах | - | Халдваргүйтгэл зохион байгуулах тоо | 2 | 2 | Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд халдваргүйтэл хийлгэх ажлыг 1 удаа Гэрэлтүүлэг ногоон байгууламж ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлж хяналт тавьж ажилласан. Дүүргийн 1, 2 дугаар хорооны хүүхдийн 5 ш тоглоомын талбай, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн нийт 24000$м^2$ талбайд Гэрэлтүүлэг ногоон байгууламж ОНӨААТҮГ-ын тусгай зориулалтын авто машинаар гүйцэтгүүлж ариутгал халдваргүйтгэл хийж ажилласан. 1, 2-р хорооны СӨХ-д орон сууцны байрнуудын орц болон зоорийн давхарт 4618м2 талбайд жавелионы уусмал бэлтгэн цэвэрлэгээндээ тогтмол ашиглах чиглэлийг өгсөн. 1-р хорооны 6 дугаар байрны зоорийн давхарын 120м3 усыг УСАТ соруулж 225м2 талбайд жавелионы уусмал бэлтгэн халдваргүйжүүлэлт, байрны бохирын шугам засварлахад Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,2 сая төгрөг зарцуулж уг ажилд хяналт тавин ажиллав. Просан хлорын ариутгалын шахмал 3 хайрцаг буюу 18 ш байгаа нийт 3 удаа ариутгал хийх бодисын нөөцтэй байна. | 100 | 100 |

43

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | 1.1.4 | **Арга хэмжээ-1.1.4.** Халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар орц болон зоорийн давхарт 14 хоногт 1 удаагийн халдваргүйжүүлэлтийг хуваарийн дагуу хийлгэх, халдваргүйжүүлэлтийн бодис авч нөөц бүрдүүлнэ. | 1,5 | Халдваргүйтгэл зохион байгуулах тоо/ талбай хэмжээ $м^2$ | 24/4618$м^2$ | 2/4618$м^2$ | 1, 2-р хорооны СӨХ-д орон сууцны байрнуудын орц болон зоорийн давхарт 4618м2 талбайд жавелионы уусмал бэлтгэн цэвэрлэгээндээ тогтмол ашиглаж байна. 1-р хорооны 6 дугаар байрны зоорийн давхарын 120м3 усыг УСАТ соруулж 225м2 талбайд жавелионы уусмал бэлтгэн халдваргүйжүүлэлт, байрны бохирын шугам засварлахад Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,2 сая төгрөг зарцуулж уг ажилд хяналт тавин ажиллав. | 100 | 100 |
| 5 | 1.1.5 | **Арга хэмжээ-1.1.5.** Ариутгал халдваргүйтгэл, хийх бодисын нөөц бүрдүүлэх, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, нийтийн тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулна. | 1,0 | Халдваргүйтгэл зохион байгуулах тоо | 17 | 2 | Багахангай Гэрэлтүүлэг ногоон байгууламж ОНӨААТҮГ нь дүүргийн 1, 2 дугаар хорооны хүүхдийн 5 ш тоглоомын талбай, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн нийт 24000$м^2$ талбайд тусгай зориулалтын авто машинаар ариутгал халдваргүйтгэлийн ажлыг гүйцэтгэв. 1, 2 дугаар хорооны СӨХ нь орон сууцны байрнуудын орц болон зоорийн давхрын 4618$м^2$ талбайд жавелионы уусмал бэлтгэн цэвэрлэгээндээ тогтмол ашиглаж байна. 1 дүгээр хорооны 6-р байрны зоорийн давхрын 120$м^3$ усыг УСАТ соруулж 225$м^2$ талбайд жавелионы уусмал бэлтгэн халдваргүйжүүлэлт хийн, байрны бохирын шугам засварлахад Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,2 сая төгрөг зарцуулав. Одоогоор просан хлорын ариутгалын шахмал 3 хайрцаг буюу 18 ш байгаа ба нийт 3 удаагийн ариутгал хийх бодисын нөөцтэй байна. | 100 | 100 |
| 6 | 1.1.6 | **Арга хэмжээ-1.1.6.** | - | Байгуулсан | 4 | 4 | Нийслэлийн хүнсээр хангах албаны | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүнсээр хангах мэргэжлийн ангиудтай хамтран ажиллаж, хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүн нөөцийг бүрдүүлнэ. | | гэрээний тоо | | | төлөвлөгөө шинэчлэгдэхтэй холбоотойгоор дүүргийн хүнсээр хангах албаны төлөвлөгөө, хүнсээр хангах албатай хамтран дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 4 худалдаа үйлчилгээний байгууллагатай хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 12 дэлгүүрийн хүнсний гол нэрийн 13 бүтээгдэхүүний бодит нөөцийн мэдээг 7 хоног бүрийн Баасан гарагт гарган УБЗАА-ны Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэст хүргэн ажиллаж байна. | | |
| **ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО (7 зорилт 22 арга хэмжээ)** | | | | | | | | | |
| **ЭРҮҮЛ МЭНД** | | | | | | | | | |
| 2.1 | | **Зорилт-2.1.**<br><br>Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдэд эрүүл зөв амьдралын дадлыг хэвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | - | 90 | Тайлангийн хугацаанд нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг дуран, чих, хамар, хоолой, шүд гэсэн 5 төрлөөр зохион байгуулж 3,1 сая төгрөг зарцуулав. Дурангийн оношилгоонд-318, чих, хамар, хоолойн үзлэгт-274 хүүхэд, умайн хүзүүний хавдрын үзлэгт-164, шүдний үзлэгт 234 нийт 990 иргэн, хүүхэд хамрагдсан байна. Үзлэгийн үр дүнд хавдрын 21 сэжигтэй тохиолдлыг илрүүлснээс 6 тохиолдол батлагдаж эмчилгээнд хамрагдаж байна. Эрт илрүүлгийн үзлэгт 4463 иргэн хамрагдахаас 1806 иргэн дүүрэгт, бусад орон нутагт 83 иргэнийг хамруулж хамрагдалт 42.3%-тай байна.БЗДХ/ДОХ-ыг илрүүлэх зорилгоор түргэвчилсэн оношлуураар тэмбүүг илрүүлэх шинжилгээнд 623 иргэн хамруулснаас 5 тохиолдлыг оношилж эмчилгээнд хамруулав. 2023 оны 11 сарын байдлаар сүрьеэгийн шинэ тохиолдол 4 батлагдсан. Эмчилгээ бүрэн дууссан 4, хяналтад | 93 | 96.6 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эмчлэгдэж байгаа 4 хүн байгаа ба тухай бүр хяналт тавин ажиллаж байна. | | |
| 7 | 2.1.1. | **Арга хэмжээ-2.1.1.** Иргэдийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх зөв дадал хэвшилд сургах, эрүүл зохистой хооллолтыг дэмжих чиглэлээр 5 сургалт зохион байгуулна | Нийслэл, дүүргийн төсөв 1.0 | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо | Нийгмийн эрүүл мэндийн сургалтад 128 иргэнийг хамруулав | 5-аас доошгүй төрлийн сургалт зохион байгуулсан байна<br>250-аас доошгүй иргэдийг сургалтад хамруулсан байа. | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор 2023 оны 02 дугаар сараас НЭМ-ийн эмч, сувилагчийг ажиллуулж иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг эрчимжүүлэн ажиллаж байна. Тайлангийн хугацаанд НЭМҮТ, Герантлогийн төв, болон дүүргийн ЭМТөвтэй хамтран 16 төрлийн сэдвээр давхардсан тоогоор 53 аж ахуйн нэгжийн 773 ажилтан албан хаагч, иргэнийг хамруулж танхимын сургалт зохион байгуулан 1,9 сая төгрөг зарцуулав.<br>Мөн Багахангай Эрүүл мэндийн төв facebook хуудсаар 282 удаагийн эрүүл мэндийн зөвлөмжийг байршуулан ажиллаж байна. | 90 | 100 |
| 8 | 2.1.2. | **Арга хэмжээ-2.1.2.** "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөрийг үргэлжлүүлж, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах | Дүүргийн төсөв 1.0 | Зохион байгуулсан ажлын тоо хэмжээ Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо | 7 удаагийн үзлэгт 74 иргэн хамрагдав. | 8-аас доошгүй үзлэг зохион байгуулж 150-аас доошгүй хүүхдийг хамруулсан байна. 50 хүүхдийг эмчилж эрүүлжүүлсэн байна. | "Эрүүл шүд - Эрүүл хүүхэд" хөтөлбөрийн хүрээнд "Амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах 2023 оны төлөвлөгөө"-г 4 зорилт түүнийг хэрэгжүүлэх 23 заалттайгаар боловсруулан хэрэгжилтийг хангаң биелэлт 95.8 хувьтай байна. УИХ-ын гишүүн шадар сайд С.Амарсайханы ажлын албатай хамтран 2023 оны 07 дугаар сард шүдний нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг зохион байгуулж 176 хүүхдийг хамруулав. Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан сургууль цэцэрлэгийн багш ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулав. Үзлэгт нийт 125 багш ажилчид хамрагдав. Амны хөндийн эрүүл мэндийн сургалтыг 33 ААНБ-т | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохион байгуулж давхардсан тоогоор 468 албан хаагч, хүүхэд хамрагдсан байна. Бага насны хүүхдийн амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханы ажлын алба, Эрүүл мэндийн төвийн хүүхдийн эмч, гэрээт шүдний Эмальдент эмнэлэг зохион байгуулж нийт 662 хүүхэд хамруулснаас шүдний өвчтэй 423 буюу 63,9% нь өвчлөлтэй гарсан байна. Амны хөндийн эрүүл мэндийн сургалтыг НШЭНТөв болон дүүргийн ЭМТ-өөс 2 удаа үе шаттай зохион байгуулж 45 ААНБ-ын давхардсан тоогоор 502 албан хаагч, 432 сурагч, 14 багш, 128 эцэг эх, хамрагдсан байна. Дүүргийн "Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн"-ийг 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж 72 сурагч оролцов. Эдгээр арга хэмжээнд 3,2 сая төгрөг зарцуулав. | | |
| 9 | 2.1.3. | **Арга хэмжээ-2.1.3.** "Эрүүл орчин-Иргэдийн сайн сайхан" III шатны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана. | Дүүргийн төсөв 2.0 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, хувь | "Эрүүл орчин-Иргэдийн сайн сайхан" III шатны хөтөлбөр 90.0%-тай хэрэгжэв. | Төлөвлөгөөний биелэлтийн хувиар тооцно | "Эрүүл орчин-Иргэдийн сайн сайхан" арга хэмжээний 2021-2022 онд хэрэгжүүлсэн төлөвлөгөөг дүүргийн ИТХ-ын зөвлөлөөр хэлэлцүүлэв. Мөн ДИТХ-ын чуулганаар 2023-2024 онд хэрэгжүүлэх 3 бүлэг 24 заалт бүхий төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. ГБХЗХХ нь 2023 онд хөгжүүлэх 30 өрхийг хороодтой хамтран сонгож үйлчилгээ үзүүлэн тус өрхийн 85 иргэнд сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулав. Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж буй Урам төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Цагдаагийн хэлтсээс зорилтот 23 | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өрхийг хяналтад авч сургалтад хамруулаад байна. Тус төлөвлөгөөний хүрээнд Та татгалз нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж 8 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулаад байна. Цагдаагийн хэлтсээс “Уусан бол бүү жолоод” “Та татгалз” арга хэмжээ, нөлөөллийн аяныг зохион байгуулж согтууруулах ундаа хэрэглэсэн 103 жолоочийг илрүүлэн хариуцлага тооцсоноос гадна байнга архи уудаг 15 иргэнийг хяналтад авч сургалтад хамруулав. Архи согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй 14, зөвшөөрөлгүй 6 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд 248 удаа хяналт тавьж 14, ААНБ-д 3 удаа зөвлөмж шаардлага хүргүүлэв. Мөн архины асуудалтай хүнд туслах зорилгоор бэлтгэгдсэн аддиктологийн нийгмийн ажилтан, Цагдаагийн хэлтсийн хороо хариуцсан байцаагчтай хамтран 2023 оны 05 сард архины хамааралтай 17 иргэнд сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулав. Насан туршийн суралцахуйн төвийн багш архины хамааралтай 30 иргэнд “Бэрхшээлийг хэрхэн даван туулдаг вэ?” сэдэвт сургалт, ахлах ангийн сурагчдад тамхи, электрон тамхины хор уршгийг таниулах “Таны сонголт танаас шалтгаална” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж 200 гаруй сурагч хамрагдсан байна. Монголын АА нийгэмлэгийн Багахангай дахь “Бид хамтдаа” бүлгийн гишүүдийн үйл ажиллагаагаа явуулах таатай нөхцөлийг бүрдүүлэх, ая тухтай байдлыг хангах зорилгоор тус бүлгийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байрны тохижилтыг ИТХ-ын ГХУСАЗСЗ-ийн санхүүжилтээр Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын албан хаагчид гүйцэтгэв. “Бид хамтдаа” бүлэгтэй хамтран 16 иргэнийг сургалтад хамруулан 5 иргэнийг архинаас татгалзуулаад байна. | | |
| **БИЕИЙН ТАМИР** | | | | | | | | | |
| 2.2 | **Зорилт 2.2** Иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангана. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | - | 90 | | МХХМГХолбоотой хамтран өсвөрийн улсын аварга шалгаруулах 1000, 2000, 3000, 5000 метрийн кросс гүйлтийн тэмцээнийг 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулж 200 гаруй өсвөрийн тамирчид, иргэд оролцов. Мөн дүүргийн БТСХороо нь хөнгөн атлетик суурьтай биеийн тамирын дасгал, хөдөлгөөнийг зохион байгуулж, дүүргийн хэмжээнд давхардсан тоогоор 95 байгууллагын 965 иргэн хамрагдав. Өвлийн улиралд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд “Багахангай 2023” өвлийн өдөрлөгийн арга хэмжээг 2023 оны 2 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, 5 төрөлт тэмцээн зохион байгуулав. Тус арга хэмжээнд 24 байгууллагын 403 ажилтан албан хаагч оролцсон байна. Уг арга хэмжээнд Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,3 сая төгрөг зарцуулав. Өвлийн спортын нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор Мөсөн дээрх шагай, Мөсний сур харвааны тэмцээнийг зохион байгуулав. Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх ая тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр спорт заалны шал, сандал, шаардлагатай техник хэрэгсэлд 90,0 сая, БТСУХорооноос техник хэрэгслийг | 95 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сайжруулахад 60,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв. | | |
| 10 | 2.2.1 | **Арга хэмжээ-2.2.1.** Нийслэлийн иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлж, нийтийг хамарсан томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. /Улаанбаатар Марафон, Иргэдийн Спортын наадам, Төрийн албан хаагчдын наадам гэх мэт/ | Дүүргийн төсөв 2,0 | Зохион байгуулсан тэмцээний тоо<br><br>Оролцсон тамирчдын тоо | 3 арга хэмжээнд 48 иргэнийг хамруулсан | 7-оос доошгүй тэмцээнд 110 иргэнийг хамруулна. | Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Улаанбаатар марафон-2023" олон улсын 8 дахь удаагийн гүйлтийн тэмцээн 2023 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулагдсан бөгөөд тус тэмцээнд дүүргээс 16 аж ахуйн нэгж байгууллагын 50 ажилтан албан хаагч "Эрүүл мэндийн 5 км-ын гүйлт"-д амжилттай оролцлоо. "Улаанбаатар марафон-2023" арга хэмжээний үеэр Баянзүрх дүүргийн БТСХорооноос зохион байгуулсан гар дээр суниалтын тэмцээнд Цагдаагийн хэлтсийн ажилтан Б.Гантулга гуравдугаар байр эзэлсэн байна.Иргэдийн Спортын наадмын анхан шатны Сагсан бөмбөг, волейбол, явган аялал, ширээний шагайн наадгайн дүүргийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулав. Уг тэмцээнд давхардсан тоогоор 1568 тамирчин оролцсон байна. Нийслэлийн Засаг даргын ивээл дор жил бүр зохион байгуулагддаг Нийслэлийн ерөнхий боловсролын сурагчдын өсвөрийн Улаанбаатар лиг Сагсан бөмбөгийн тэмцээн 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр, Волейболын тэмцээн 2023 оны 04 дүгээр сарын 05-06-ны өдрийн хооронд зохион байгуулагдав. Уг тэмцээнд дунд насны ангилалд 12-14 насны 29 тамирчин оролцож 1,4 сая төгрөг зарцуулав. Мөн дүүргийн өсвөрийн аварга шалгаруулах сагсан бөмбөг, волейболын тэмцээнийг 2023 оны 03 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулав. Уг тэмцээнд нийт давхардсан тоогоор 226 | 90 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүүхэд оролцож 1,9 сая төгрөг зарцуулав. Монголын хүүхдийн спортын VII наадмын анхан шатны тэмцээнийг дүүрэгт сагсан бөмбөг, волейбол, даам, шатар гэсэн 4 төрлөөр зохион байгуулж, нийт 260 тамирчин оролцсон байна. Мөн тус наадмын Волейболын нийслэлийн бүсийн тэмцээнд эрэгтэй, эмэгтэй 2 багийн 16 тамирчин оролцсон ба тус тэмцээнд нийт 3,5 сая төгрөг зарцуулав. Монголын хүүхдийн спортын зуны VII наадмын шигшээ тэмцээнд 2023 оны 06 сарын 19-28 өдрүүдэд Баянхонгор аймагт Чөлөөт бөхийн ангилалд 6 тамирчин оролцов. | | |
| 11 | 2.2.2. | **Арга хэмжээ-2.2.2.** Мэргэжлийн холбоодтой хамтран дүүрэгт улс, бүсийн чанартай тэмцээн уралдаан зохион байгуулах, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | Дүүрэг, байгууллагын төсөв 5.0 | Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ Тэмцээн уралдаанд оролцсон иргэдийн тоо | 2021 онд 5 тэмцээн зохион байгуулж 632 иргэнийг хамруулав. | Улс, бүсийн чанартай 1 тэмцээн Биеийн тамир, спортын 10-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. Зохион байгуулсан ажлын үр дүнгээр тооцно | “Багахангай марафон-2023” хэт холын улсын аварга шалгаруулах гүйлтийн тэмцээнийг 4 дүгээр сард зохион байгуулав. Тэмцээнд Япон, Америк, Голланд, Киргизстан 5 улс, 15 аймаг, 6 дүүрэг, 23 клубын 700 гаруй тамирчин оролцов. Тайлангийн хугацаанд МХХМГХ, Сагсан бөмбөг, Волейбол, Үндэсний бөх, Бадминтон, Сурын харваа, Шагайн харвааны салбар зөвлөл, Дартс, Гар дээр суниалт, Буудлага гэсэн 10 холбоодтой хамтран 9 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулж 48 багийн 1340 тамирчин хамрагдан 11,3 сая төгрөг зарцуулав. Монголын Хөл бөмбөгийн холбоотой хамтран ажиллах хүсэлтийг дүүргийн Засаг даргын 2023 оны 1/345, 1/827 тоот албан бичгээр хүргүүлснээр 11 дүгээр сарын 02-ны өдөр Монголын хөл бөмбөгийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн Д.Батнасан дүүрэгт ажиллаж хамтын ажиллагааны талаарх уулзалт зохион байгууллаа. | 100 | 100 |

51

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх ая тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр спорт заалны шал, сандал, шаардлагатай техник хэрэгсэлд 90,0 сая төгрөг, БТСУХорооноос техник хэрэгслийг сайжруулахад 60,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв. | | |
| **БОЛОВСРОЛ** | | | | | | | | | |
| 2.3 | | **Зорилт-2.3 Боловсрол:** Хүн бүрт чанартай боловсролыг тэгш хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр хангана. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 92 | 2022-2023 оны хичээлийн жилд 2,4 дэх жилийн сургалтад СӨБ-6,ЕБС 9 багш хамрагдлаа. Багшийн мэргэжил дээшлүүлэх 1,5,10 жилийн үндсэн сургалтад ерөнхий боловсролын нийт 14 багш хамрагдсан бол НБГ-ын APLUS модуль сургалтад 38 багш хамрагдав. “Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого” танилцуулах сургалтад 50 багш хамрагдаж 0,5 мянган төгрөг зарцууллаа.2023-2024 оны хичээлийн жилд 1,5,10 жилийн үндсэн сургалтад ЕБС-2 багш, СӨББ-уудаас -5 багш хамрагдах ба Боловсролын ерөнхий газраас сар бүр зохион байгуулагддаг хуваарьт сургалтад 19 багш хамрагдсан байна 2023-2024 оны хичээлийн жилийн зорилтот болон сонголтод сургалтад 42 багш 12 дугаар сарын 11-ээс 01 дүгээр сарын 28-ны хооронд хамрагдахаар бүртгүүлээд байна. | 95 | 97.5 |
| 12 | 2.3.1 | **Арга хэмжээ-2.3.1.** ЕБС, СӨБ-ын сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сайжруулж, хүүхдэд ээлтэй эрүүл | Төсөл хөтөлбөр 10.0 | Тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллагын тоо | 5 төрлийн 4.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдав. | 3 байгууллагыг сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангасан | Дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг Орика Монголиа ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Англи хэлний кабинетыг иж бүрэн тохижуулж 2,5, 44 дүгээр цэцэрлэгт 8 хайрцаг тоглоом авахад 1,0, Кемекс ХХК нь Байгалийн ухааны кабинетыг тохижуулахад 5,0 сая төгрөгийг зарцуулав. “Хангай” цогцолбор сургууль багш хөгжлийн | 90 | 90 |

52

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | аюулгүй орчинг бүрдүүлнэ. | | | | байна. | зардлаас 31 ширхэг tablet, 7 notebook авч тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж хичээлийн 2 байранд урсгал засварт 25,5 сая төгрөг зарцуулав. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/110 дугаар захирамжийн дагуу "Хүүхдийн сургуулийн автобус" төсөл арга хэмжээний хүрээнд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 307,3 сая төгрөгийн үнэ бүхий Dongfeng загварын автобусыг ЗДТГ-ын өмчийн бүртгэлд авч ашиглаж байна. Орчны аюулгүй байдлын үнэлгээ хийх үзлэгийг 1 удаа зохион байгуулж 48 зөрчлийг илрүүлэн 12 ААНБ-д засаж сайжруулах үүрэг даалгаврыг өгөв. 2023-2024 оны хичээлийн жилд боловсролын салбарт 1,0 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдэв. УИХ-ын гишүүн Ц.Сандаг-Очир "Хангай" цогцолбор сургуульд ширээ, сандал, ухаалаг самбар, 207, 44 дүгээр цэцэрлэгт хөгжим техник хэрэгсэл олгож 100,0 сая, дүүргийн ИХТ-аас Хөгжмийн кабинетын тохижилтод 1,7 сая, "Eduten" хөтөлбөр хэрэгжүүлж байгаа 6 багшид 10,0 сая төгрөгийн өртөг бүхий 6 ширхэг "Chromenotebook" зөөврийн компьютер хүлээлгэн өгөв. Орика Монголиа ХХК Англи хэлний кабинетэд 2,5, 44 дүгээр цэцэрлэгт 8 хайрцаг тоглоом авахад 1,0, Кемекс ХХК Байгалийн ухааны кабинетыг тохижуулахад 5,0 сая төгрөгийг зарцуулав."Хангай цогцолбор сургууль"-ийн авто зогсоол, авто замын ажлыг "Неон гэгээ" ХХК Нийслэлийн төсвөөр 410,7 сая төгрөгөөр гүйцэтгэж 10 хувьтай байна. Японы элчин сайдын яамны "Өвсний үндэс-хүний аюулгүй | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байдлыг хангах буцалтгүй тусламж"-ийн хөтөлбөрийн хүрээнд 44 дүгээр цэцэрлэгийн харьяа "Алтай" бүлэгт 156,2 сая төгрөгийн их засвар хийгдэхээр тендер зарлагдаж "Силикон арт дизайн" ХХК шалгарав. Мөн Төмөр замын 183 дугаар цэцэрлэгт 256,0 сая төгрөгийн их засвар хийгдэв. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/110 дугаар захирамжийн дагуу "Хүүхдийн сургуулийн автобус" төсөл арга хэмжээний хүрээнд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 307,3 сая төгрөгийн үнэ бүхий Dongfeng загварын автобусыг авч ашиглаж байна. "Хангай" цогцолбор сургууль багш хөгжлийн зардлаас 31 ширхэг tablet, 7 notebook авч тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж хичээлийн 2 байранд урсгал засварт 25,5 сая төгрөг зарцуулав. Орчны аюулгүй байдлын үнэлгээ хийх үзлэгийг 2 удаа зохион байгуулж 48 зөрчлийг илрүүлэн 12 ААНБ-д засаж сайжруулах үүрэг даалгаврыг өгч ажиллав. | | |
| 13 | 2.3.2 | **Арга хэмжээ-2.3.2.**<br><br>Тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээлтэй/ хүүхдийг үе тэнгийнхэнтэйгээ хамт суралцах боломжийг бүрдүүлнэ. | - | Нийт суралцагчдад ХБХүүхдийн эзлэх хувь | ЕБС-д<br><br>3 хүүхэд суралцаж байна. | ХБХүүхдийн эзлэх хувийг нэмэгдүүлсэн байдлаар тооцно | Дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 31 хүүхэд бүртгэлтэй байгаа ба байнгын асаргаа авдаг нийт 25 хүүхэд байна. Үүнээс 10 хүүхэд тусгай болон жирийн сургуульд, 2 хүүхэд цэцэрлэгт, 2 хүүхэд Насан туршийн суралцахуйн төвд хамрагдан ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр суралцаж байна. Дүүргийн боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлыг тайлангийн хугацаанд 1 удаа зохион байгуулж, цэцэрлэг болон сургуульд хамрагдахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй 4 хүүхэд болон тэдний асран хамгаалагчтай уулзалт | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ярилцлага зохион байгуулж 2 хүүхдийг насан туршийн суралцахуйн төвд хамруулах, 1 хүүхдийг 44 дүгээр цэцэрлэгт хамруулж хүүхэд тус бүрийн онцлогт тохирсон ганцаарчилсан тусгай хөтөлбөрөөр боловсролын үйлчилгээг үзүүлж байна. JICA олон улсын байгууллагын тэгш хамруулан сургах хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх хөтөлбөрт 1 багшийг 56 багц цагийн сургалтад хамруулан үндэсний сургагч багшаар бэлтгэв. | | |
| 14 | 2.3.3 | **Арга хэмжээ-2.3.3.**<br><br>Сургууль цэцэрлэгийн "Үдийн хоол" хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүүхдийг эрүүл, баталгаат хоол хүнсээр хангахад хяналт тавина. | - | Үдийн хоол хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоо<br><br>Хяналт шалгалтын тоо | 411 хүүхдийг үдийн цай хөтөлбөрт хамруулав. | 4-өөс доошгүй удаа хяналт тавьсан байна<br><br>411 хүүхдийг хамруулсан байна. | 2022-2023 оны хичээлийн жилд Хангай цогцолбор сургуулийн "Үдийн хоол" хөтөлбөрт 16 бүлгийн 435 сурагч хамрагдав. СӨББ-ууд нь хоол хүнсний материалыг "Налайх хангамж" ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүн ашиглаж байна. Тайлангийн хугацаанд хүүхдийг эрүүл хоол хүнсээр хангаж буй эсэхэд 2 удаагийн хяналт тавьж 3 зөрчил илрүүлэн хугацаат үүрэг даалгавар өглөө. 2023-2024 оны хичээлийн жил эхэлсэнтэй холбогдуулан Нийслэл, дүүргээс 2 удаа "Үдийн хоол" хөтөлбөрт хяналт тавьж 5 зөрчлийг илрүүлэн зөвлөмж зөвлөгөө өгч ажиллав. "Хангай" цогцолбор сургуулийн цайны газрыг стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Засаг даргын орлогч З.Төмөртөмөөд дэмжлэг хүсэх тухай дүүргийн Засаг даргын 2023 оны 09-р сарын 26-ны өдрийн 1/731 тоот албан бичгийг хүргүүлэв. 2023-2024 оны хичээлийн жилд 16 бүлгийн 412 сурагч Үдийн хоол | 90 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөтөлбөрт хамрагдаж байна. СӨББ-ууд нь хоол хүнсний материалыг "Налайх хангамж" ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүн ашиглаж байна. Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар, Нийслэлийн ерөнхий боловсролын "Хангай" цогцолбор сургууль гурвалсан гэрээ байгуулан 1-р хичээлийн байранд "Сэтгэлийн гэгээ" ХХК, 2-р хичээлийн байранд "Сутайн цант" ХХК нь Үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тайлангийн хугацаанд хүүхдийг эрүүл хоол, хүнсээр хангаж буй эсэхэд НХХААГ-аас 1, дүүргээс 2 удаагийн хяналт тавьж 7 зөрчил илрүүлэн хугацаат үүрэг даалгавар өгч ажиллав. Тус сургуулийн Цайны газарт шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гарган шийдвэрлэж өгөхийг хүссэн албан бичгийг УИХ-ын гишүүн Ц.Сандаг-Очир, Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтэц хариуцсан орлогч Ж. Сандагсүрэн БЕГ, НБГ, Өвсний үндэс-т тус тус хүргүүлснээс гадна Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгуулахаар хүргүүлэв. | | |
| 15 | 2.3.4 | **Арга хэмжээ-2.3.4.** Насан туршийн боловсролын төв байгуулах ажлыг холбогдох байгууллагад уламжилж, иргэд, хүүхэд, залуучуудад насан туршийн боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ | 10 төрлийн сургалт зохион байгуулж 211 иргэнийг хамруулав. | Зохион байгуулсан ажлын үр дүнгээр тооцно | Дүүргийн Засаг даргын 2023 оны А/165 дугаар захирамжаар Насан туршийн суралцахуйн төвийн бүтэц орон тоог шинэчлэн баталсан ба Боловсролын багц хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан БЕГ-аас тус төвийг 8 багш ажилтны орон тоотойгоор ажиллуулах жишиг орон тооны санал ирүүлээд байна. 2024 онд Насан туршийн суралцахуйн төв батлагдсан орон тоогоор үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай 512,2 сая | 100 | 100 |

56

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийн төсвийн төсөөллийг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэв. 2023-2024 оны хичээлийн жилд Насан туршийн суралцахуйн төвд 15 сурагч суралцаж байна. Насан туршийн суралцахуйн төвийн багш нар үндсэн 5 чиглэлд 160 удаагийн сургалтаар 3512 иргэнд, 21 удаагийн нөлөөллийн ажлаар 894 иргэнд хүрч ажилласан байна. | | |
| **НИЙГМИЙН ХАЛАМЖ:** | | | | | | | | |
| 2.4. | **Зорилт 2.4.** Дүүргийн хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-т болон амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 92 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар тогтоолын дагуу нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрт 65 иргэнд 171,2 сая, байнгын асаргаа шаардлагатай 0-16 настай хүүхдэд олгох тэтгэмжид 24 хүүхдэд 71,1 сая төгрөг зарцуулсан байна. Тайлангийн хугацаанд 18 төрлийн арга хэмжээнд 117 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан байна. Байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 6 эцэг, эх асран хамгаалагчийг Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох сургалтад хамруулаад байна. Ахмад настны 9 төрлийн хөнгөлөлт тусламжид 707 ахмад настныг хамруулж 64,9 сая төгрөг, хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 61 иргэнийг нийгмийн халамжийн тэтгэвэрт хамруулж 212,9 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох 5 төрлийн хөнгөлөлт, тусламжид 107 иргэнийг хамруулан 20,8 сая төгрөг зарцуулсан байна. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | 2.4.1. | **Арга хэмжээ-2.4.1.** Ажил эрхэлдэггүй, нийгмийн халамжид хамрагддаггүй зорилтот бүлгийн өрх, иргэдийг нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулан, хамт олны бүлэг бүрдүүлэн орлогын эх үүсвэртэй болгох нөхцөлийг бүрдүүлнэ. | Халамжийн сан 3.8 | Орлогын эх үүсвэр нэмэгдсэн өрхийн тоо | 6 өрхийн 3 бүлэгт 3,8 сая төгрөгийн санхүүжилт олгов. | Нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд 6 өрхийг хамруулна. | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг 3532 иргэнд үзүүлж 2,9 тэрбум төгрөг зарцуулсан байна. Ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэдэд амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор зохион байгуулсан сургалтад 39, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 37 иргэн хамрагдаж нийт 3,3 сая төгрөг зарцуулав. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх арга хэмжээнд 7 бүлгийн 14 иргэнийг хамруулж 13,0 сая төгрөг зарцуулсан байна. | 100 | 100 |
| 17 | 2.4.2. | **Арга хэмжээ-2.4.2.** Дүүргийн ахмад настан, тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, нөлөөллийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ | Халамжийн сан 64,8 | Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ Хамрагдсан хүний тоо | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 708 иргэнд 64,8 сая төгрөгийг зарцуулав. | Зохион байгуулсан ажлын үр дүнгээр тооцно | Ахмад настны 9 төрлийн хөнгөлөлт тусламжид 707 ахмад настныг хамруулж 64,9 сая төгрөг, хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 61 иргэнийг нийгмийн халамжийн тэтгэвэрт хамруулж 212,9 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох 5 төрлийн хөнгөлөлт, тусламжид 107 иргэнийг хамруулан 20,8 сая төгрөг зарцуулсан байна. Дүүргийн Засаг даргын 2023 оны А/20 дугаар захирамжаар Билгийн тооллын хаврын тэргүүн сар, Сар шинийн баярыг угтан дүүргийн 80-аас дээш настай 50 ахмад настанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж 2,7 сая төгрөг, ААНБ-дад харьяалалгүй ахмад настанг хүлээн авч "Ахмадаа сонсъё" арга хэмжээг зохион байгуулж ЗДТГ-аас 4,4 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 656.490 төгрөгийг тус тус | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зарцуулав. Мөн дүүргийн УЗХорооноос хөгжлийн бэрхшээлтэй 3, ахмад настан 2 нийт 5 иргэнд тэргэнцэр олгосон байна. "Иргэдийн оролцоо сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилтот жил"-ийн хүрээнд зохион байгуулсан 11 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 287 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулав. | | |
| 18 | 2.4.3 | **Арга хэмжээ-2.4.3.** Хүмүүнлэгийн чиглэлээр гадаадын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, зорилтот бүлгийн өрх, иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулна. | ОУБ 4.0 | Төсөл хөтөлбөрт хамрагдсан өрх, иргэний тоо | 2021 онд 44 өрхийг гадаадын төсөл хөтөлбөрт хамруулав. | 60 өрхийн 180 иргэнийг төсөл хөтөлбөрт хамруулсан байна. | Тайваний гэр бүлийг дэмжих санд 31 өрхийн 107 хүүхэд, Кристина нобелийн хүүхдийг дэмжих санд 4 өрхийн 4 хүүхэд хамрагдаж байна. Мөн Кристина нобелийн хүүхдийг дэмжих санд 10 хүүхдийг хамруулахаар нөхцөл байдлын үнэлгээг хийж холбогдох байгууллагад саналыг хүргүүлэв. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Солонгосын хөрөнгө оруулалттай "Энхүүслэн хайрын гар" ТББ нь бүтэн өнчин болон хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 45 хүүхдэд гарын бэлэг гардуулав. Мөн АНУ-д амьдран суудаг Г.Дашдондогийн гэр бүл дүүргийн 50 хүүхдэд гарын бэлэг гардуулав. Дэзерет олон улсын байгууллага "Хангай" цогцолбор сургуулийн 70 хүүхдэд цүнх, хичээлийн хэрэгслийн дэмжлэг үзүүлэв. Японы "Хүүхдийг ивээх сан"-тай хамтран ажиллахаар хүсэлт гаргасанаар дүүрэгт тус сангийн төлөөлөл ажиллаж хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай уулзаж хамтран ажиллах чиглэлээр тодорхойллоо. | 100 | 100 |
| **Зорилт 2.5. Хөдөлмөр эрхлэлт:** Бүх нийтийн бүрэн, бүтээмжтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ | | | | | | | | | |
| 2.5 | | **Зорилт 2.5.** Бүх нийтийн бүрэн, бүтээмжтэй, зохистой | - | Арга хэмжээний хэрэгжилт, | 90 | 92 | Тайлангийн хугацаанд нийтийг хамарсан ажилд 54 иргэнийг хамруулж 19,8 сая төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | | дундаж хувь | | | Үндэсний зөвлөлийн 2023 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаа"-ны хүрээнд 19 иргэнд 143 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон. Дүүргийн ХХҮХ ань өөрийн фейсбүүк пэйж хуудсаар хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаарх 10 удаагийн видео, шторкийг иргэдэд хүргэсэн байна. | | |
| 19 | 2.5.1 | **Арга хэмжээ-2.5.1.** Ажил олгогч, аж ахуй нэгж байгууллагуудад зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна. | Дүүргийн төсөв 0,5 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 арга хэмжээ зохион байгуулж 4 ААНБ-ыг хамруулсан | 2 арга хэмжээ | Тайлангийн хугацаанд 28 ажил олгогч байгууллага, аж ахуйн нэгжээс 101 ажлын байрны захиалга ирэв. Нийт байнгын болон түр ажлын байранд 71 иргэн зуучлагдсан байна. 337 иргэний мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн цахим E-JOB системд модуль тус бүрээр бүртгэж, мэдээллийн санг баяжуулан ажиллаж байна.Ажлын байр шинээр бий болсон, байхгүй болсон сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээллийг холбогдох байгууллагаас авч нэгтгэн, ажил хайгч иргэдэд цаг алдалгүй хурдан шуурхай мэдээлж, ажлын байрны захиалга тус бүрд бүртгэлтэй ажилгүй иргэдээс ажил олгогчийн шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн зуучлах ажлыг зохион байгуулж ХХҮЕГ болон НХХГ-т хүргүүлж байгаагаас гадна 14 хоног тутам дүүргийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд мэдээлэл хүргэж байна. Мөн хөдөлмөр эрхлэлтийн цахим систем Ejob платформын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлын хүрээнд 2 шторк, 3 зурган зөвлөмжийг ХХҮХэлтсийн фэйсбүүк хаягаар сурталчилж ажилласан байна. 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр "Дарь-Овооны эзэд" сургалтын | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагатай хамтран ажил хайгчаар бүртгэлтэй 13 иргэн, “Хангай” цогцолбор сургуулийн 9-12 дугаар ангийн 175 сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгууллаа. 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдсан “Нээлттэй хаалганы өдөр”-өөр сул ажлын байрны захиалгын талаарх мэдээллийг шторк –ийг 128 иргэнд хүргэж ажиллав Дүүргийн ХАБЭА-н салбар зөвлөл Форум ланд ХХК-тай хамтран "ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ АЖИЛ-БИДНИЙ СУУРЬ ЭРХ-2023" аяны хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй ажлын байрыг бий болгох чиглэлээр 4 аж ахуйн нэгж байгууллагын 72 ажилтан албан хаагчдыг чадавхжуулах сургалтад хамруулав. Нийт 37 шинэ ажлын байрны мэдээлэл болон 369 иргэний мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн цахим E-JOB системд модуль тус бүрээр бүртгэж, мэдээллийн санг баяжуулан ажиллав. ХХҮХ нь статистик тайлан, мэдээ, мэдээллийг батлагдсан маягтын дагуу тогтоосон хугацаанд нэгтгэн нийт 6 удаагийн тайлан мэдээг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон ХХҮЕГ болон НХХГ-т хүргүүлж байгаагаас гадна 14 хоног тутам дүүргийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд мэдээлэл хүргэж байна. Дүүргийн вэб сайтад Нээлттэй Багахангай цэсийг шинээр үүсгэн сул ажлын байрны мэдээллийг байршуулж байна. Одоогоор 6 ААНБ-ын 38 ажлын | | |

| СОЁЛ УРЛАГ | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6 | **Зорилт 2.6.** Хүүхэд залуучууд, иргэдийг хотын соёлд суралцуулах, мэргэжлийн байгууллагатай хамтран соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулна. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 92 | Соёл, урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, нийгмийн соён гэгээрлийг дэмжих, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх зорилгоор "Соёлын сэргэлт 2023" аяныг дүүрэгт 2023 оны 06 дугаар сард зохион байгуулав. Соёлын ажилтнуудад зориулсан "Маркетинг 2.0" чадавхжуулах сургалт, Үндэсний бахархал үнэт зүйл, Хотын соёл, Соёлын орон зай сэдэвт илтгэлүүдийг тавьж соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн, Улаанбаатар хотын музейн үзэсгэлэн, урлагийн тоглолт зэрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж 150 хүнийг хамруулав. Иргэд хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор "Open mic", хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулсан "Караоке" тэмцээн, ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулсан "Хангай эгшиглэн" богино хэмжээний өгүүллэг, яруу найргийн тэмцээнийг зохион байгуулав. Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Д.Лувсаншаравын нэрэмжит "Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг" шалгаруулах 29 дэх удаагийн уралдаанд "Хангай" цогцолбор сургуулийн 60 хүүхдийн бүрэлдэхүүнтэй "Хараацай" хамтлаг амжилттай оролцож хөгжмийн зохиолч Л.Галмандах сангийн нэрэмжит | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шагналаар шагнагдаж гала тоглолтод оролцлоо. Тайлангийн хугацаанд соёлын чиглэлээр нийт 53 арга хэмжээ зохион байгуулж 400 гаруй иргэн хамрагдсан байна. Соёлын ордны мэргэжлийн багш нарын тоглолтыг 4 удаа зохион байгуулав. | | |
| 24 | 2.6.1 | **Арга хэмжээ-2.6.1.** Мэргэжлийн урлагийн байгууллагуудтай хамтран соёл, урлагийг түгээн дэлгэрүүлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах, дугуйлан секцийг хороодод тогтмол хичээллүүлнэ. | Дүүргийн төсөв 1.0 | Зохион байгуулагдсан соёл, урлагийн арга хэмжээний тоо Хамрагдсан хүний тоо | - | Мэргэжлийн урлагийн 2 байгууллагын тоглолтыг иргэд олон нийтэд хүргэнэ. 5 нэр төрлийн дугуйлан секц хичээлүүлсэн байна. | Тайлангийн хугацаанд урлагийн тоглолт 14, хурал цуглаан, сургалт 39, соёл олон нийтийн ажил 26, арга хэмжээ 9, кино үзвэр 7, номын сангийн үйлчилгээ 394 удаа буюу нийт 486 соёл урлагийн олон талт үйл ажиллагаа явуулж 12300 гаруй иргэн хамрагдсан байна. Соёлын яам, НСУГ хамтран Соёлын бүтээлч сар аяны хүрээнд "Соёлын эрхийн бичиг"-ийн тандалт судалгааг 21 аймаг, 9 дүүрэгт хэрэгжүүлж байна. Энэхүү судалгаанд Хангай цогцолбор сургуулиас сонгогдсон 16-18 насны 67 хүүхдийг бүрэн хамрагдав. Улаанбаатар театр, ШШГЕГ-ын Соёмбо чуулга, Монгол Улсын хүүхэлдэйн театрын тоглолт тоглогдсон байна. Мэргэжлийн урлагийн байгууллагатай хамтран зохион байгуулсан арга хэмжээнд 6,5 сая төгрөг зарцуулж, давхардсан тоогоор 1600 гаруй иргэн хамрагдав. | 100 | 100 |
| 25 | 2.6.2 | **Арга хэмжээ-2.6.2.** Хүүхэд залуучууд, иргэдийг хотын соёлд суралцуулах, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн санал санаачлагыг дэмжиж | Байгууллагын төсөв 1.5 | Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ | - | Зохион байгуулсан ажлын үр дүнгээр тооцно | "Бужиг" арга хэмжээг 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийн хооронд 7 хоног бүрийн Пүрэв гаригт зохион байгуулж 15 ААНБ, өртөө, зөрлөгийн 1400 гаруй албан хаагч, иргэд оролцов. Соёл, урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, нийгмийн соён гэгээрлийг дэмжих, үндэсний | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамтран ажиллана. | | | | | нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх зорилгоор "Соёлын сэргэлт 2023" аяныг дүүрэгт 2023 оны 06 дугаар сард зохион байгуулав. Соёлын ажилтнуудад зориулсан "Маркетинг 2.0" чадавхжуулах сургалт, Үндэсний бахархал үнэт зүйл, Хотын соёл, Соёлын орон зай сэдэвт илтгэлүүдийг тавьж соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн, Улаанбаатар хотын музейн үзэсгэлэн, урлагийн тоглолт зэрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж 150 хүнийг хамруулав. Австралийн Элчин сайдын яам, Монголын номын сангийн холбоо, Хүүхдийн номын Жангар редакцаас "Хил хязгааргүй номын төсөл"-өөс Соёлын ордонд 70 гаруй ном гардуулж хүүхдийн номын фондыг баяжуулав. Соёлын ордны дэргэдэх Номын санг Улаанбаатар нийтийн номын төв номын сангийн харьяанд ажиллуулах тухай дүүргийн Засаг даргын 2023 оны 1/646 дугаар албан бичиг, тооцоо судалгааг гарган холбогдох байгууллагад хүргүүлэв. | | |
| ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД | | | | | | | | | |
| 2.7 | | **Зорилт 2.7.** Гэр бүлийн гишүүн бүрт чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажиллагаа зохион байгуулж, гэр бүлд үзүүлэх хамгааллын үйлчилгээг сайжруулна. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 92 | "Эцэг эх, асран хамгаалагчдын анхдугаар зөвлөгөөн", Эцэг эхийн уулзалт арга хэмжээг 2 удаа зохион байгуулж эцэг эхчүүдээс хүүхдэдээ тавих ахнаарлаа сайжруулах, эцэг эхчүүд оролцоогоо нэмэгдүүлэхээр уриалга гарган ажиллаж байна. Тайлангийн хугацаанд Хүүхэд хамгаалагч 3 иргэнийг ажиллуулж, хамгааллын үйлчилгээ үзүүлж байна. ГБХЗХХ-ээс "Илрүүлэлт" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулав. Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл | 97 | 96.6 |

66

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Оюунлаг Багахангайчууд арга хэмжээний хүрээнд "Оролцоод хөгжье" мэтгэлцээний тэмцээнийг 3 үе шаттай зохион байгуулж 2,1 сая төгрөг зарцуулав. "Хайрын гар" нөлөөллийн аянд 154 иргэн, 12-17 насны 49 сурагч нэгдэж буйгаа илэрхийллээ | | |
| 26 | 2.7.1 | **Арга хэмжээ-2.7.1.** Хүүхэд, залуучуудад үндэсний өв уламжлал, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, хотын соёлд суралцуулах, гэр бүлийн боловсрол олгох чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг сайжруулна | 1.9 | Сургалт нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Гэр бүлийн боловсрол олгох нөлөөллийн чиглэлээр 8 сургалтыг зохион байгуулав. | Гэр бүлийн боловсрол олгох нөлөөллийн үйл ажиллагаанд 500 иргэнийг хамруулсан байна. | Дүүргийн ИТХ, ЗДТГ, ГБХЗХХ, Цагдаагийн хэлтэс, Хангай цогцолбор сургууль хамтран хүүхдийн сэтгэл зүйн онцлог, гэмт хэрэг, зөрчилд өртөж холбогдож буй шалтгаан нөхцөл түүнээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсрол олгох асуудлаар 280 эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарыг хамруулан 2023 оны 01, 05 дугаар сард 2 удаа зөвлөгөөн зохион байгуулж сургалт, зөвлөмж, мэдээлэл хүргэж ажиллав. Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг ОУ-ын өдрийг жил бүрийн 4 дүгээр сарын 30-ны өдрийн хүрээнд "Хайрын гар" сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг дүүргийн Хүүхдийн зөвлөл, ГБХЗХХ хамтран зохион байгуулав. Тус арга хэмжээний үеэр хүүхдийг зодож шийтгэх бус "Уламжлалт Монгол ухаанаар хүмүүжүүлье" зөвлөгөөг иргэдэд өгсөн байна."Хайрын гар" нөлөөллийн аянд 154 иргэн, 12-17 насны 49 сурагч нэгдэж буйгаа илэрхийллээ. Мөн гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сэдвийн хүрээнд 26 удаагийн сургалтыг 570 иргэнд зохион байгуулсан байна. | 100 | 100 |
| 27 | 2.7.2 | **Арга хэмжээ-2.7.2.** Залуучуудын сурч боловсрох, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлж, | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 удаагийн сургалтад 21 хүүхэд, залуучууд хамрагдав. | Хөгжлийг дэмжих арга хэмжээнд 50 | "Эерэг хандлага- Эрүүл залуус" аяныг өрнүүлж оюутны эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг зохион байгуулж 50 хүүхэд залуучууд хамрагдсан байна. Мөн Амьдрах | 90 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ. | | хамрагдсан залуучуудын тоо | | залуучуудыг хамруулна. | ухааны боловсрол олгох сургалтыг 3 удаа зохион байгуулж нийт 65 залуу хамрагдав. Дүүргийн Залуучуудын хөгжлийн төвөөр 12 сургалт нөлөөллийн арга хэмжээ, 4 хөгжлийн арга хэмжээ зохион байгуулагдаж давхардсан тоогоор 618 залуучууд буюу нийт залуучуудын 45%-ийг хамруулав. | | |
| 28 | 2.7.3 | **Арга хэмжээ-2.7.3.** Дүүргийн "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана. | Дүүргийн төсөв 3.0 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, хувь | Дүүргийн "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилт 23 заалтыг хэрэгжүүлэв. | Төлөвлөгөөний биелэлтийн хувиар тооцно | Дүүргийн "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр"-ийн 1-р шатны биелэлтийг дүүргийн ИТХ-ын чуулганаар хэлэлцүүлж тодорхой үр дүнд хүрсэн буюу 95 хувьтай үнэлүүлэв. Жендэрийн хэвшмэл ойлголт хандлагыг өөрчлөх зорилгоор "Харилцан хүндэтгэе" аяныг "Надаас, танаас, биднээс эхлэлтэй", "Жендэрийн хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-ыг "Хүндэл хамгийн тод гэрэл" уриан дор тус тусзохион байгуулав. Тус аянд 11 ААНБ-ын 179 ажилтан албан хаагчид тус аянд 4 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 469 иргэн, 136 хүүхэд хамрагдаж цахимаар 9 төрлийн мэдээллийг түгээн 1000 орчим хүний хандалт авсан байна. Төв талбайд "ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ АЛХАЛТ"-ыг зохион байгуулж 12 байгууллагын 80 гаруй иргэн хамрагдлаа.Эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор "Эмэгтэйчүүдийн манлайлал" уулзалт, арга хэмжээг 2 удаа зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд давхардсан тоогоор 80 гаруй эмэгтэй удирдах албан тушаалтан хамрагдлаа. | 100 | 90 |
| **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО ( 6 зорилт 23 арга хэмжээ)** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3.1 | **Зорилт 3.1.** Нийслэл, дүүргийн өмчийг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 92 | 2023 оны 11 дүгээр сарын байдлаар дүүргийн Засаг даргын Тамгын газар нь нийслэл, дүүргийн өмчийн байрыг 4 аж ахуйн нэгжид зах зээлийн бодит үнэлгээг үндэслэн түрээслүүлж, төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэн 8.3 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Мөн үндсэн үйл ажиллагааны орлогоор ХАААлба 1.6 сая төгрөг, Соёлын ордон 3.6 сая төгрөгийн ажил үйчилгээний орлогыг тус тус бүрдүүлэв. | 100 | 100 |
| 29 | 3.1.1 | **Арга хэмжээ-3.1.1.** Нийслэл, дүүргийн өмчийг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх | - | Түрээсийн орлого, сая төгрөг | 15.6 сая төгрөг | 17.1 сая төгрөг | 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дүүргийн Засаг даргын Тамгын газар нь нийслэл, дүүргийн өмчийн байрыг 4 аж ахуйн нэгжид зах зээлийн бодит үнэлгээг үндэслэн түрээслүүлж, төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэн 8,3 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Мөн үндсэн үйл ажиллагааны орлогоор ХАААлба 1,6 сая төгрөг, Соёлын ордон 3,6 сая төгрөгийн ажил үйчилгээний орлогыг тус тус бүрдүүлэв. ЖДҮДТ нь НӨХГ-аас байр ашиглалтад авах тушаал шийдвэр ирээгүй байгаа тул түрээслүүлэх боломж бүрдээгүй байна. | 100 | 100 |
| | 3.2 | **Зорилт 3.2.** Нийслэл, дүүргийн хэмжээнд газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, татварт хамрагдалтыг нэмэгдүүлэх, татвар ногдуулах, хураах үйл ажиллагаанд технологийн дэвшил нэвтрүүлэн, хялбаршуулна. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 92 | 2023 оны 10 дугаар сарын 24-ний байдлаар газрын төлбөрт өссөн дүнгээр 49 сая 234.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 49 сая 325.7 мянган төгрөг төвлөрүүлж биелэлт 100.2 хувьтай, үл хөдлөх хөрөнгийн албан татварт өссөн дүнгээр 32,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 27 сая 017.3 мянган төгрөг төвлөрүүлж биелэлт 84.4 хувьтай тус тус биелсэн байна. 2023 онд 1688 иргэн аж ахуйн нэгжид ноогдуулалт хийснээс 1622 иргэн аж ахуйн нэгжид 71.305,110 төгрөгийн нэхэмжлэх үүсгэн ажиллалаа. | 100 | 100 |

69

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Арга хэмжээ-3.2.1.** Улс, нийслэл, дүүргийн татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх | | | | | | | |
| 30 | 3.2.1 | | - | Төсөвт төвлөрүүлэх орлого, сая төгрөг | Улсын төсвийн орлого 1,775.1 сая төгрөг, Нийслэлийн төсвийн орлого 116.5 сая төгрөг, Орон нутгийн төсвийн орлого 1,164.8 сая төгрөг, Нийт татварын орлого 3,081.5 сая төгрөг | Улсын төсвийн орлого 1,698.2 сая төгрөг, Нийслэлийн төсвийн орлого 101.9 сая төгрөг, Орон нутгийн төсвийн орлого 1,162.1 сая төгрөг, Нийт татварын орлого 2,962.3 сая төгрөг | Дүүргийн Засаг даргын 2023 оны А/10 дугаар захирамжаар 2023 оны дүүргийн төсвийн орлого, зарлагын сар, улирлын хуваарийг батлуулав. 2023 онд дүүргийн төсвийн орлогыг нийслэлээс авах санхүүгийн дэмжлэг 5,071.9 сая төгрөг, орон нутгийн татварын орлого 1,247.1 сая төгрөг, Төсвийн байгууллагын өөрийн орлого 19.3 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 493.8 сая төгрөг, ОНХС-гаас 382.7 сая төгрөгөөр тус тус бүрдүүлэхээр төлөвлөж сар улирлын хуваарийг батлуулсан. Төсвийн төлөвлөлтийн 2023 оны программд орон нутгийн 13 байгууллагын төсвийн хуваарийг шивж төлбөр тооцоо хийх нөхцлийг бүрдүүлэв. Мөн орон нутгийн төсвийн байгууллагуудаас ирүүлсэн 2023 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг үндэслэн жилийн эцсийн байдлаар өр авлагагүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн Дүүргийн Засаг даргын 2023.12.04-ны А/226 тоот захирамжаар 2023 оны төсвийн сар, улирал, жилийн хуваарьт өөрчлөлтийг оруулсан. | 100 | 100 |
| 31 | 3.2.2 | **Арга хэмжээ-3.2.2.** Газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, татварт хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | - | Төсөвт төвлөрүүлэх газар, үл хөдлөх эд хөрөнгийн орлого, сая төгрөг | Газраас 54.8 сая төгрөг, Үл хөдлөх хөрөнгөөс 38.5 сая төгрөг | Газраас 59.7 сая төгрөг, Үл хөдлөх хөрөнгөөс 40.0 сая төгрөг | Дүүргийн Газрын төлбөрт өссөн дүнгээр 122,5 сая төгрөг төвлөрүүлэхээс 133,7 сая төгрөг төсөвт төвлөрүүлэн төлөвлөгөө 109.0 хувьтай, Үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөвлөгөөгөөр 96,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 63,9 сая төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 67.0 хувьтай биелсэн байна. | 100 | 100 |
| 3.3 | | **Зорилт 3.3** Орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн санг үр | | | - | - | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн тайлан мэдээг хуулийн хугацаанд shilendans.gov.mn сайт | 83 | 83.3 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дүнтэй зарцуулж, иргэдэд нээлттэй мэдээлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх. | | | | | болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж ажиллав. Үүнд:<br>- Төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээ 2023 оны 1-10 дугаар сарын мэдээ,<br>- Төсвийн зарлагын гүйцэтгэлийн 2022 оны 4 дүгээр улирал, 2022 оны жилийн эцэс, 2023 оны 1, 2, 3 дугаар улирлын гүйцэтгэл,<br>- ТЕЗ-ийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,<br>- ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн Аудитын нэгдсэн дүгнэлт,<br>- Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан,<br>- ТЕЗ-ийн 2023 оны хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлан.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан 27 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг шилэн дансанд байршуулсан. | | |
| 32 | 3.3.1 | **Арга хэмжээ-3.3.1.** Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | - | Иргэдийн оролцоо, хувь | 47 | 70 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих төсөл хөтөлбөр арга хэмжээний саналд 4 ажлын саналыг хүргүүлээд байна. Нийслэл болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээнд иргэдээс цахим санал, асуулга авах ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хооронд зохион байгуулж, 1204 иргэн санал өгсөн ба 403 иргэн цахимаар, 833 иргэн цаасаар санал өгч саналын цахим санал асуулгын явц 46.2 хувьтай байна. Дүүрэгт 2024 оны санал асуулгад дараах төсөл хөтөлбөр арга хэмжээний саналыг хэрэгжүүлэхээр | 50 | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | иргэдээс санал авлаа. Үүнд:<br>- Камержуулалт<br>- Гэр хорооллын дэд бүтэцийн төв байгуулах<br>- Тохижилт, засвар үйлчилгээ<br>- Гэрэлтүүлэг<br>- Иргэд олон нийтэд зориулсан усан бассейн бүхий сургалтын төв<br>- Автомашины зогсоол байгуулах<br>- Хойд болон баруун жигүүрийн дулаан, хэрэглээний халуун усны шугамын шинэчлэл<br>- 1, 2 дугаар хороог холбосон ногоон байгууламж нэмэгдүүлэх | | |
| 33 | 3.3.2. | **Арга хэмжээ-3.3.2.** Үнэлгээний хороонд иргэдийн төлөөллийг томилох, хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлын явцад хяналт тавих комиссын бүрэлдэхүүнд иргэдийн төлөөллийг оруулж оролцоог нэмэгдүүлэх | - | Иргэдийн төлөөлөл, хувь | Давхардсан тоогоор 104 иргэн | 10 | 25 ажлын үнэлгээний хороо, шууд худалдан авалтын 8 ажлын хэсэгт нийт 33 иргэний төлөөллийг томилон ажиллуулав. | 100 | 100 |
| 34 | 3.3.3. | **Арга хэмжээ-3.3.3.** 2022 онд хэрэгжиж дууссан, он дамжин хэрэгжиж буй ажлууд болон 2023 онд хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын талаар танилцуулга, гарын авлага бэлтгэж иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах. | - | Гарын авлагын тоо, хувь | 150 ширхэг гарын авлага | 250 ширхэг гарын авлага | 2022 оноос он дамжин хэрэгжиж буй ажлууд болон 2023 оны хөрөнгө оруулалтын ажлын талаарх танилцуулга мэдээллийг ХААА дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд 2 удаа, Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч Б.Болормаа Засаг даргын өргөтгөсөн хуралд 4 удаа тус тус хүргэн ажиллав.<br>"Иргэдийн төсөв" эмхтгэл номыг "Masam-2" төслийн багтай хамтран 100 ширхэгийг хэвлүүлэхээр бэлтгээд байна. | 100 | 100 |

72

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4 | **Зорилт 3.4.**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 92 | 2023 оны дүүргийн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 13 бараа ажил үйлчилгээ батлагдсан. Үүнд:<br>- Нээлттэй тендер шалгаруулалтаар 4,<br>- Шууд худалдан авалтаар 8,<br>- Харьцуулалтын аргаар 7,<br>- Зөвлөх үйлчилгээний 5<br>- Олон нийтийн оролцоотой 2,<br>- Гэрээ шууд байгуулах аргаар 1 ажил байна. 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар цахим системээр зохион байгуулсан 23 ажлын тендер шалгаруулалтын үр дүнг /tender.gov.mn/ цахим системд тухай бүр ил тод байдлаар нийтлэн иргэдийг мэдээллээр хангаж ажиллав. Үр дүн гараагүй 2 ажил байна. 2023 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 11, ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 3, НОНХС-гийн хөрөнгөөр 8, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 5, НЗС-гийн хөрөнгөөр 2, Олон улсын зээл тусламжаар 1, байгууллагын хөрөнгөөр 3 нийт ажил арга хэмжээний худалдан авах ажиллагаа 93.3 хувьтай хэрэгжиж байна. Мөн шууд худалдан авалтын аргаар 8, Олон нийтийн оролцоотой тендер шалгаруулалтын журмаар 2, цахимаар 23 ажлын тендерийг зарлаж нийт 81 компани оролцсоноос шалгарсан 27, шалгараагүй 54 компанийн материалыг хуулийн үндэслэлийн хамт Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -д тухай бүр ил тод байдлаар нийтлэн иргэдийг мэдээллээр хангаж ажиллав. Тус онд дүүргийн ИТХ- | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ын тогтоолоор нийт 10 иргэнийг үнэлгээний хороонд томилон ажиллуулахаар батлагдсан бөгөөд 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 33 ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулахаар тусгагдсаны 25 ажлын үнэлгээний хороо, 8 ажлын хэсэгт 1, 2 дугаар хорооны А3 гэрчилгээ бүхий иргэдийн төлөөллийг томилон ажиллуулсан байна. | | |
| 35 | 3.4.1 | **Арга хэмжээ-3.4.1.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг холбогдох журмын дагуу 100 хувь цахим системээр зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүнг /tender.gov.mn/ цахим системд ил тод нийтэлсэн байх. | - | Хөрөнгө оруулалтын ажлын тоо, хувь | 51 | 10 | Худалдан авах ажиллагааны албаны төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр "Өнөөдөр" сонин болон холбогдох сайтуудад байршуулав. Мөн дүүргийн хэвлэл мэдээлэл болон пэйж хуудсуудад олон нийтэд нээлттэй мэдээлэн шилэн дансны сайтад 27 мэдээ байршуулан ажиллаж байна.<br>- Нээлттэй тендер шалгаруулалтаар 3,<br>- Шууд худалдан авалтаар 5,<br>- Харьцуулалтын аргаар 19 ажил зарлагдсан.<br>33 ажлын тендер шалгаруулалтын үр дүнг /tender.gov.mn/ цахим системд тухай бүр ил тод нийтлэн иргэдийг мэдээллээр хангаан ажиллав. | 100 | 100 |
| 36 | 3.4.2 | **Арга хэмжээ-3.4.2.** Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн тайлан мэдээг хуулийн хугацаанд shilendans.gov.mn сайт болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж ажиллав. Үүнд:<br>- Дүүргийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн 2023 оны 1-11 дүгээр сарын мэдээ,<br>- Төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлчилгээ худалдан авах ажлын төлөвлөгөө болон улс, нийслэл, ОНХСан, дүүргийн хөрөнгө оруулалтын зарцуулалтыг shilendans.gov.mn сайтад байршуулж иргэдэд нээлттэй мэдээлэх. | | | | | хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт,<br>- 2023, 2024 оны төсвийн төслийн санал, дүүргийн 2023 оны төсөвт орсон өөрчлөлт,<br>- Төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээ<br>- 2023 оны 1-11 дүгээр сарын мэдээ,<br>- Төсвийн зарлагын 2023 оны 1, 2, 3 дугаар улирлын гүйцэтгэл,<br>- ТЕЗ-ийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,<br>- ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн Аудитын нэгдсэн дүгнэлт,<br>- 2023 оны Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө,<br>- Шилэн дансны тухай бүр цэсэнд 60, сар бүр цэсэнд 32, бүтэн жил цэсэнд 4, нийт 96 мэдээ байршуулав.<br>Мөн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан 33 төсөл хөтөлбөр арга хэмжээг шилэн дансанд байршуулсан. | | |
| 3.5 | | **Зорилт 3.5.**<br>Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлж хэвшүүлнэ. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 92 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах ажлын хүрээнд ААНБ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 заалт болгон тусган оруулж, биелэлтийг сар тутам гаргаж ирүүлэхийг үүрэгжүүлэн ажиллав. Дүүргийн улс, орон нутгийн төсвийн 18 байгууллагын 96 дансны орлого, зарлагын гүйлгээнд Төрийн сангийн цахим системээр өдөр тутам хяналт тавьж байна. Төсвийг хэмнэлтийн | 100 | 100 |

75

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | горимд шилжүүлж ажиллах тухай Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласанаар 2023 оны 12 дугаар сарын 1-ны байдлаар 6,689.7 сая төгрөг байхаас 5,688.8 сая төгрөг зарцуулж 1,000.9 сая төгрөгийн хэмнэлттэй тус тус ажилласан байна. | | |
| 37 | 3.5.1 | **Арга хэмжээ-3.5.1.** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан, төсөв, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах ажлын хүрээнд ААНБ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 заалт болгон тусган оруулж, биелэлтийг сар тутам гаргаж ирүүлэхийг үүрэгжүүлэн ажиллав. Дүүргийн улс, орон нутгийн төсвийн 18 байгууллагын 96 дансны орлого, зарлагын гүйлгээнд Төрийн сангийн цахим системээр өдөр тутам хяналт тавьж байна. Орон нутгийн төсвийн 6, ТШЗ-ийн 5, ОНӨААТҮГ 3 байгууллага, дүүргийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн 2021, 2022 оны жилийн эцсийн аудитын шалгалтаар баталгаажсан тайланг хүлээн авч нэгтгэсэн. ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гарган Нийслэл дэх Төрийн аудитаар шалгуулж баталгаажуулж, дээд шатны байгууллагад хянуулан нэгтгэлд хамруулсан. Аудитын шалгалтаар “Зөрчилгүй” гэсэн санал дүгнэлтийг авч ажиллалаа. Дүүргийн улс, орон нутгийн төсвийн 18 байгууллагын 70 дансны орлого, зарлагын гүйлгээнд Төрийн сангийн төлбөр тооцоогоор дамжуулан хяналт тавин ажиллаж байна. МУЗГ-аас гаргасан төсвийг зөв зохистой ашиглах, хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай 2021 оны 2 дугаар | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, тэвчиж болох урсгал зардлуудыг тодорхой хувиар бууруулж ажиллах талаар төсвийн байгууллага, ОНӨААТҮГ-т албан бичгээр тухай бүр зөвлөмж, чиглэл хүргүүлэн үйл ажиллагаанд нь хяналт, шаардлага тавин ажиллалаа. 2023 оны 12 дугаар сарын 1-ны байдлаар 6,689.7 сая төгрөг байхаас 5,688.8 сая төгрөг зарцуулж 1,000.9 сая төгрөгийн хэмнэлттэй түс түс ажилласан байна, Сүүлийн 3 жилийн өссөн дүнгээр төлөвлөгөө 18,945.0 сая төгрөг байхаас гүйцэтгэлээр 17,466.0 сая төгрөгийг зарцуулж 1,479.0 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ. | | |
| 3.6. | | **Зорилт 3.6.** Шинээр бизнес эхлэх эхний үе шатны хүндрэлийг даван туулах, цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд жижиг дунд үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ бий болгоно. | 24,0 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100 | 100 | Дүүргийн бичил бизнес эрхлэх хүсэлтэй, жижиг зээл олгох, зээлийн өмнөх сургалтад 8 иргэн, Уламжлалт гар урлалыг хөгжүүлэх боломж шийдэл-2023" сургалтад 2 иргэнийг хамруулав. 5 удаа үзэсгэлэн худалдаа арга хэмжээд нийт давхардсан тоогоор 15 албан хаагч, 8 үйлдвэрлэл эрхлэгч, 2 хоол үйлдвэрлэгч ХХК 28 иргэн хамрагдсан. Нийт 13,7 сая төгрөгийн борлуулалт хийж ашиг орлогоо нэмэгдүүлэв. | 98 | 94.6 |
| 38 | 3.6.1 | **Арга хэмжээ-3.6.1.** "Багахангайн үйлдвэрлэл технологийн парк"-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, шил, шилэн бүтээгдэхүүн, барилгын шилэн | - | Санал хүргэх байгууллагын тоо | "Багахангайн ҮТП-ын хөгжлийн төлөвлөгөө" боловсруулах | 1 | Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-т экспортын зориулалттай "Тэнь-Агро" ХХК Нөөшилсөн махан бүтээгдэхүүний цогцолбор үйлдвэр, "Эл Эс Рэйлвэй" ХХК Төмөрбетон дэр-Бетон хийц эдлэлийн үйлдвэр, "Сарьдаг Хангайн Оргил" ХХК Кокс эрчим хүчний | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хийцийн үйлдвэрийг барьж байгуулах, санал санаачилгыг дэмжиж ажиллана. | | | тендер зарлагдан гэрээ байгуулах шатандаа байна. | | үйлдвэрийн нэгжээр ороод байна. “Сарьдаг Хангайн Оргил” ХХК Кокс эрчим хүчний үйлдвэрийг барих бүтээн байгуулалтын ажил болон техникийн нөхцөл гаргуулахаар Зам тээврийн хөгжлийн яаманд 2023 оны 32 дугаар албан бичгийг хүргүүлсэн байна. “Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын цахилгаан хангамжид нэн шаардлагатай байгаа 8,8 тэрбум төгрөгийн өртөг бүхий дэд бүтцийн чиглэлээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлыг 2024 оны улсын төсөвт суулгуулах дэмжлэг хүссэн дүүргийн Засаг даргын 2023 оны 1/276 дугаартай албан бичгийг Монгол Улсын шадар сайд, УИХ-ын гишүүн С.Амарсайханд хүргүүлэв. "Ян Сарьдаг Оргил" ХХК-ийн БНХАУ дахь толгой компани "Фен ян" группийн ерөнхийлөгч болон тус компанийн ажлын хэсгийн төлөөлөл хүрэлцэн ирж, үйлдвэрлэл, технологийн паркийн дарга болон дүүргийн Засаг дарга нарт төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулж, Тус паркын 6 зураг, төслийн ажил хийгдэхээс Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/961 дүгээр захирамжаар 230,0 сая төгрөгийн өртөг бүхий 4 зураг, төслийн ажлын санхүүжилтийг шийдвэрлүүлэв. Дүүргийн Засаг даргын захирамжаар үнэлгээний хороо байгуулагдан тендерийн ажлыг зохион байгуулан Багахангайн Үйлдвэрлэл, технологийн паркийн<br>• Авто замын зураг, төслийн ажилд “Ихэрмөнх” ХХК<br>• Дулаан хангамж, ус хангамж, ариутгал татуургын дотно, гадна зураг төслийн ажилд | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | "Түмэн амгалан ордон" ХХК Инженерийн шугам сүлжээ, түнелийн системийн зураг төслийн ажилд "Гидро дизайн инноваци" ХХК тус тус шалгарч зураг төсвийн ажил гүйцэтгэхээр болоод байна. Зам, тээврийн хөгжлийн яамнаас Д.Батхүү, "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн Хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан замын орлогч Ш.Нямсүрэн даргаар ахлуулсан 15-20 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2 удаа ирж ажилласан. Засгийн газрын тогтоолоор 2021 оны 227 дугаар тогтоолоор Шил шилэн бүтээгдэхүүний үйлдвэрлэх, үйлдвэрлэл технилогийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон. Тус байгууллага нь "CNBM" ХХК-наар "Үйлдвэрлэл технологийн парк"-ийн зураг, төслийн ажлыг 57000 ам. доллараар гүйцэтгэж байна. | | |
| 39 | 3.6.2 | **Арга хэмжээ-3.6.2.** Дүүргийн Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төвөөр дамжуулан жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчид, хоршоо, нөхөрлөлийн санхүүгийн асуудал буюу зээл тусламжид хамрагдах нөхцөлийг бүрдүүлнэ. | - | Зээл тусламжинд хамрагдсан үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо | Жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдэд төсөл хөтөлбөр, зээлд хамрагдах талаарх мэдээллийг хүргэсэн. | Жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдийг төсөл хөтөлбөрт хамруулна. | Дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсээс "Хөдөлмөр эрхлэлт 2023" нээлтийн өдөрлөгийг 2023 оны 04 дүгээр сарын 12-18-ны өдрүүдэд дүүргийн төв талбай болон 1,2 дугаар хорооны гэр хороолол, УБТЗ-ын өртөөгөөр жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, бичил бизнес эрхлэх хүсэлтэй иргэдэд сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулав. Тус арга хэмжээний сург талчилгааны ажилд 1,2 сая төгрөг зарцуулав. Жижиг зээл олгох, зээлийн өмнөх сургалтад 18 иргэн хамруулж 2 иргэд 60,0 сая төгрөгийн зээлийг жилийн 8,8 хувийг хүүтэй 36 сарын хугацаатай Төрийн банкаар дамжуулж олгосон. Нийт 20 иргэн 130,0 сая төгрөгийн зээлийг Хөдөлмөр эрхлэх | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дэмжих сангаас олгов. Үүнд:<br>• Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэгт 4 иргэний 40,0 сая төгрөг<br>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэний санхүүгийн дэмжлэгт 1 иргэний 5,0 сая төгрөг<br>• Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх санхүүгийн дэмжлэгт 5 иргэн 25,0 сая төгрөг<br>Мөн Жижиг зээл олгох, зээлийн өмнөх сургалтад 18 иргэнийг хамруулж 2 иргэнд 60,0 сая төгрөгийн зээл, Финтек богино хугацааны эргэлтийн зээлд 42 иргэн бүртгүүлж 30 иргэн тус бүр 400.000 төгрөгийн зээл нийт 12,000,000 төгрөгийн зээлийг олгоод байна.<br>Тайлангийн хугацаанд 42 иргэнийг байнгын, 6 иргэнийг түр ажлын байраар хангав. | | |
| 40 | 3.6.3 | **Арга хэмжээ-3.6.3.**<br>Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, оролцуулах замаар өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн зах зээл дэх борлуулалтын сувгийг нэмэгдүүлнэ. | 3,0 | Зохион байгуулсан үзэсгэлэн худалдааны тоо | 11 | 8-аас дээш | Нийслэлээс зохион байгуулсан Сар шинийн баярыг угтсан "Амар байна уу-2023", "Их хотын бүсгүйчүүд-2023" үзэсгэлэн худалдааны арга хэмжээ, Нийслэлийн соёл урлагийн газар, НЖДҮҮДТ, дүүргийн Соёлын ордонтой хамтран "Соёлын сэргэлт-2023", Батлан хамгаалах яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран "Монголд зочлох жил"-ийн хүрээнд "Буянт-Ухаа" нисэх буудлын хөөрөх зурвваст "Эйр шоу-2023", "Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв" НӨҮГ, Нийслэлийн Соёл урлагийн газар, Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | газар хамтран “Бүтээлч болгоё” ардын урлаг, гар урлаачдын нэгдсэн арга хэмжээ, "Даншиг наадам- Хүрээ цам 2023" шашин соёлын арга хэмжээ, “Нүүдэлчин-Дэлхийн соёлын фестиваль” арга хэмжээний зохион байгуулалтад оролцсон. Дүүргээс зохион байгуулсан:<br>• “Цагаан сар” үзэсгэлэн худалдаа<br>• “Багахангай марафон -2023” Улсын аварга шалгаруулах гүйлтийн тэмцээ<br>• Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр<br>• Хичээлийн шинэ жилийн өдрийг угтсан “Хичээл орлоо”<br>• “АЛТАН НАМАР-2023”<br>• "Нээлттэй хаалга"-ны өдөрлөгт оролцов.<br>Дүүргийн бичил бизнес эрхлэх хүсэлтэй, жижиг зээл олгох, зээлийн өмнөх сургалтад 8 иргэнийг хамруулав. нийт 10 үзэсгэлэн худалдаа, 4 арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 109 албан хаач, үйлдвэрлэл эрхлэгч, хоол үйлдвэрлэгч, иргэн хамрагдсан. Нийт 31,2 сая төгрөгийн борлуулалт хийж ашиг орлогоо нэмэгдүүлэв. | | |
| 41 | 3.6.4 | **Арга хэмжээ-3.6.4.** Жижиг дунд үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгчдийг сургалтад хамруулан чадавхжуулна. | 1,0 | Зохион байгуулсан сургалтын тоо | 10 /118 | 5-аас дээш | Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн дэргэдэх жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгч давхардсан тоогоор 94 иргэн 9 төрлийн сургалтад хамрагдав. | 100 | 100 |
| 42 | 3.6.5. | **Арга хэмжээ-3.6.5.** Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг түшиглэн ажлын | - | Ажлын байраар хангагдсан иргэний тоо | 8 | 8-аас дээш | ЖДҮҮДТөвийн байранд дүүргийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй<br>• Хувцас захиалга засвар-7 | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байраар хангана. | | | | | • Үсчин-1<br>• Бараа, материалны худалдаа-2<br>• Бэлэг дурсгал-1<br>• Хүнс, худалдаа-1<br>• Алт, мөнгөний дархан-1<br>• Эсгий урлал-1<br>• Ноос ноолуур бүтээгдэхүүн-1<br>Нийт 15 иргэнг ажлын байраар хангах, борлуулалтыг дэмжин ажиллаж байна. Мөн дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн хөдөлмөр эрхлэлт дэмжих сангаас ажлын байр бий болгох хадгалах, бичил бизнес эрхлэгч иргэдийн үйл ажиллагааг өргөжүүлэх, сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэг олгох ажлын хүрээнд 10 иргэнд 70,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. | | |
| 43 | 3.6.6 | **Арга хэмжээ-3.6.6.** Олон улсын болон ТББ-уудтай хамтран Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ. | - | Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэний тоо | 1 | 2-оос доошгүй | МУ-ын Соёлын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нийслэлийн ЖДҮҮДТав хамтран "Шилдэг 100 бүтээл" шалгаруулалтын арга хэмжээнд дүүргээс 2 иргэн хөгжмийн зэмсэг, модон сийлбэрийн төрөлд шалгарч батламж авав. 2023.04.13-ны өдөр "Уламжлалт гар урлалыг хөгжүүлэх боломж шийдэл-2023" сургалтад 2 иргэнийг хамруулав. Олон улсын байгууллагатай хамтран УБ хотын Сүхбаатарын талбай дээр "Бүтээлч болгоё" сэдэвт 15 орны 9 дүүргийн гар урлаачдын үзэсгэлэн худалдаанд дүүргээс 20 иргэн оролцов. | 90 | 70 |
| 44 | 3.6.7 | **Арга хэмжээ-3.6.7.** Орон сууцуудын зоорийн давхрыг ард иргэдэд ашиглуулах нөхцөл боломжийг бүрдүүлнэ. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100 | 100 | Дүүргийн 1 дүгээр хорооны Хангай өргөө СӨХ-ны орон сууцны 3 байрны 10 зоорийн давхрыг 10 иргэнд, 2 дугаар хорооны Их хангай өргөө СӨХ-ны орон сууцны 6 байрны 12 зоорийн давхрыг | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 12 иргэнд түрээсийн гэрээтэйгээр ашиглуулж байна. Дүүргийн 2 дугаар хорооны орон сууцны 5 дугаар байрны 1 дүгээр орцонд иргэн Б.Мөнх-Адъяа 6,0 сая төгрөгөөр засварлаж Дартсын “Оч” клуб байгуулан үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. | | |
| 45 | 3.6.8 | **Арга хэмжээ-3.6.8.** Иргэдэд үйлчилгээний чиглэлээр ашиглуулах гэрээ байгуулан эзэмшүүлнэ. | - | Зоорийн давхарыг түрээсийн гэрээ байгуулах тоо | 14 | 14 | Дүүргийн 1 дүгээр хорооны Хангай өргөө СӨХ-ны орон сууцны 3 байрны 10 зоорийн давхарыг 10 иргэнд, 2 дугаар хорооны Их хангай өргөө СӨХ-ны орон сууцны 6 байрны 11 зоорийн давхарыг 11 иргэдэд түрээсийн гэрээтэйгээр ашиглаж байна. Орон сууцны зоорийн давхарын гэрээг 2024 онд шинэчлэн байгуулах үүрэг, чиглэлийг СӨХ-дод өгч ажиллав. | 100 | 100 |
| 46 | 3.6.9 | **Арга хэмжээ-3.6.9** Хүнс, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулан, худалдан борлуулах сүлжээг боловсронгуй болгоно. | 20,0 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | ЗДТГ-ын ТХҮХ, ХАА-н тасаг, ЖДҮДТ хамтран дүүргийн хүн амыг эх орны хөрсөнд ургасан төмс, хүнсний ногоогоор хангаж, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулан иргэдэд худалдаалах, жижиг дунд бизнес эрхлэгч иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор төмс, хүнсний ногоо, цагаан идээний өргөтгөсөн худалдааг 2023 оны 08 дугаар сарын 25, 09 дүгээр сарын 18-ны өдрүүдэд 1 дүгээр хороо, дүүргийн Төв талбайд зохион байгууллаа. Уг үзэсгэлэн худалдаагаар дүүргийн төмс, хүнсний ногоо тариалдаг 4 иргэн, Сэлэнгэ аймгийн тариаланч 1 иргэн, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 3 иргэн оролцож 17 нэр төрлийн хүнсний ногоо, нарийн ногоо, мах, сүү, цагаан идээ худалдаалж 3,2 сая төгрөгийн борлуулалт хийв. | 100 | 100 |

82

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 47 | 3.6.10 | **Арга хэмжээ-3.6.10.** Мал амьтныг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах, усалгаа, өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ. | 7.0 | Нөөцний хэмжээ (тн) | 16 | 25 | “Дүүргийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын дагуу 25 ААНБ-ын ажилтан, албан хаагчдаас 5,2 сая төгрөг төвлөрөөд байна. Хороодоос ирсэн судалгааг үндэслэн малчдын бэлтгэх шаардлагатай өвс тэжээлийн хэрэгцээний мэдээ болон малчдын өөрийн хүчээр бэлтгэсэн өвс тэжээлийн судалгааг гарган дүүргийн Онцгой байдлын хэлтэст хүргэн ажиллав. Мал амьтныг байгаль цаг агаарын төлөв байдал, аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор малчид болон иргэдэд 7 хоног бүрийн цаг агаарын мэдээг цахим орчинд байршуулан ажиллаж байна. | 100 | 100 |
| 48 | 3.6.11 | **Арга хэмжээ-3.6.11.** Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн аж ахуй эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, иргэдэд эрүүл, баталгаатай хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх, худалдан борлуулах сүлжээг боловсронгуй болгоно. | 1.0 | Тариалах талбай хэмжээ/ ургац хураалт (га, тн) | 7га/6,8тн | 4га/7тн | Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгээс иргэд аж ахуйн нэгжүүдэд жилийн 4 улиралд тасралтгүй нарийн ногоо хэрхэн тарьж ургуулах вэ сургалтыг зохион байгуулав. Тус сургалтад газар тариалан эрхлэгчдээс 12 төлөөлөл оролцов. Хаврын тариалалтыг дэмжих бодлогын хүрээнд хүнсний нарийн ногоо тариалах хүсэлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэхээр 13 төрлийн хүнсний нарийн ногооны үрийг ХХАГ-аас авч 1,2 дугаар хорооны ажлын албанд хүлээлгэн өгснөөр 6 ААНБ, 88 айл өрх тариалж, дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 895,757 төгрөг зарцуулав. Дүүргийн хэмжээнд 6 га газар тариалалт хийхээс 4,13 га газарт төмс, хүнсний ногоо болон жимс, жимсгэнэ тариалж 36,6 тн ургац хураав. ЗДТГ, ЖДҮҮДТ хамтран дүүргийн хүн амыг эх орны хөрсөнд ургасан төмс, хүнсний ногоогоор хангах, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг | 100 | 100 |

83

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулан иргэдэд худалдаалах, жижиг дунд бизнес эрхлэгч иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор төмс, хүнсний ногоо, цагаан идээний өргөтгөсөн үзэсгэлэн худалдааг 2 удаа зохион байгуулав. | | |
| 49 | 3.6.12 | **Арга хэмжээ-3.6.12.** Мал амьтныг халдварт паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх, вакцинжуулах, эмчлэх, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулна. | 8.0 | Зохион байгуулах ажлын тоо/хамрагдах малын тоо | 2/43274 | 2/38100 | Халдварт болон шүлхий, шимэгч өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор вакцинжуулах ажлыг 9 удаа зохион байгуулан давхардсан тоогоор 63585 толгой мал амьтныг хамруулж 99,8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан бөгөөд мал эмнэлгийн улсын байцаагчийн зүгээс тарилгын явц, вакцины зарцуулалт, устгал, малын эрүүл мэндийн үзлэг, өрхийн дэвтрийн бүртгэл, баталгаажилт зэрэгт хяналт тавьж ажилласан. Тус ажлыг дүүргийн Мал эмнэлгийн тасаг, "Цэф трейд" МЭҮН-тэй хамтран гүйцэтгэж, дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 20,6 сая төгрөг зарцуулав. | 100 | 100 |
| 50 | 3.6.13 | **Арга хэмжээ-3.6.13.** Багахангай дүүрэгт малын гаралтай түүхий эд, арьс шир, сүү, сүүн бүтээгдэхүүн худалдан авах, боловсруулах үйлдвэрлэл үйлчилгээг төвлөрүүлэх, малын тэжээлийн усалгаатай газар тариалан хөгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ. | 2.0 | Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн өрнүүлэх | - | 1 | Багахангай сүү ХХК 270 га газарт малын тэжээл тариалахаас тайлангийн хугацаанд 110 га газарт тариалаад байна. Малын гаралтай түүхий эдийг худалдаалах цэгийг төвлөрүүлэх зорилгоор "Сүү" ХК-тай холбогдож дүүрэгт сүү худалдан авах цэг байгуулах талаар хүсэлт хүргүүлсэн бөгөөд тус байгууллагаас дүүргийн холбогдох албан тушаалтантай уулзалт зохион байгуулахаар болсон. Сүү ХК-нд дүүргийн малчин бөгөөд мал бүхий өрхөөс борлуулах боломжтой сүүний судалгааг гарган хүргүүлсэн. | 90 | 70 |
| 51 | 3.6.14 | **Арга хэмжээ-3.6.14.** Хөдөө аж ахуйн салбарын | 2.0 | Зохион байгуулах тоо | - | 1 | Хөдөө аж ахуйн салбарын ажиллагсдын зөвлөгөөнийг 2024 онд зохион байгуулахаар төлөвлөн | - | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажилсагсдын зөвлөгөөн зохион байгуулна | | | | | ажиллаж байна. | | |
| ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО ( 10 зорилт 29 арга хэмжээ) | | | | | | | | | |
| 4.1 | | **Зорилт 4.1.** Иргэдийг мэдээ, мэдээллээр ханган, иргэдэд ажлаа тогтмол тайлагнана. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 91 | Дүүргийн www.bagakhangai.ub.gov.mn сайтад 2023 оны сүүлийн хагас жилийн байдлаар 265 мэдээ мэдээлэл байршуулж, 2023 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар 10696 хандалт авсан байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган 221 захирамж, 55 тушаалыг info.shilendans.gov.mn сайтад байршуулсан, "Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар" фэйсбүүк хуудаст эхний хагас жилийн байдлаар 337 мэдээ мэдээлэл, дүүрэгт болж буй арга хэмжээний талаарх 38 видео контент байршуулж, 18 шторкыг пэйжид байршуулж иргэд, олон нийтийг мэдээ мэдээллээр ханган ажиллав. Сайтын өнгө загвар дизайн шийдэл бусад нэмэлт зүйлүүдийг шинэчлэн 10 дэд цэс шинээр нэмж мэдээллүүдийг тогтмол шинэчлэн дүүргийн Засаг даргын 162 захирамжийг байршуулав. shilen.gov.mn сайтын шалгуур үзүүлтээр сайтын үнэлгээг 100%-д хүргэн ажиллаа. Сайтын мэдээллүүдийг тогтмол шинэчлэн бүртгэл хөтлөн ажиллаж байна. | 95 | 100 |
| 52 | 4.1.1 | **Арга хэмжээ-4.1.1.** "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгуулах | - | Өдөрлөгийн тоо, Хамрагдах иргэдийн тоо | 1<br>150 | 2<br>200 | "Нээлттэй хаалганы өдөрлөг" буюу ажлаа танилцуулах өдөрлөгийг 3 удаа зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд "Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" ЗГ-ын 419-р тогтоолын танилцуулга, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаарх мэдээлэл, дүүрэгт буй ажлын байрны | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сул орон тооны мэдээлэл, Прокурорын байгууллагын танилцуулга, Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг хүргэн, дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, компаниуд үйл ажиллагааны мэдээлэл, бүтээгдэхүүний дээжийг олон нийтэд танилцуулан ажиллалаа. Өдөрлөгт дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй төр болон хувийн хэвшлийн 26 аж ахуйн нэгж байгууллага оролцон, 17 байгууллага 40 төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 500 гаруй иргэнд үзүүлж ажиллалаа. | | |
| 53 | 4.1.2 | **Арга хэмжээ-4.1.2.** Дүүргийн веб сайт болон бусад мэдээллийн сувгуудаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэх | - | Иргэдэд хүргэсэн мэдээллийн тоо | 600 | 650 түүнээс дээш | Дүүргийн www.bagakhangai.ub.gov.mn сайт, "БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР" facebook группээр дамжуулан иргэдэд тогтмол мэдээллийг хүргэн, ажлаа тайлагнан ажиллалаа. Тайлангийн хугацаанд сайтаар 262 мэдээ мэдээлэл, 5 шторк байршуулж, Facebook группээр дамжуулан нийт 335 мэдээ мэдээлэл, дүүрэгт зохион байгуулагдсан арга хэмжээний 10 видео контентийг байршуулан, 2000 гаруй иргэдэд мэдээлэл хүргэлээ. Мөн хороодын цахим хуудас болон зар мэдээний самбар, Нээлттэй хаалганы өдөрлөг, Явуулын нэг цонхны үйлчилгээ, удирдлагуудын иргэдтэй хийх уулзалтаар дамжуулан, улс, нийслэл, дүүргийн бодлого шийдвэрийг танилцуулан, хууль эрх зүйн мэдлэгийг иргэдэд олгон ажиллаж байна. 2023 онд дүүргийн веб сайтыг шинэчлэх ажлыг "Magic gloud media LLC" компаниар гүйцэтгүүлэн, сайтын өнгө загвар дизайныг өөрчилж, мэдээлэл | 90 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хайх нөхцлийг бүрдүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл авах боломжоор хангаж, 10 дэд цэсийг нэмэлтээр үүсгэн мэдээллийг тогтмол шинэчилж байна. | | |
| 4.2 | | **Зорилт 4.2.** Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлнэ. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 70 | 75 | Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлэхээр нийт 10 байгууллагын 22 албан хаагч БНХАУ, БНСУ, ОХУ, Нидерланд улсад ажиллан, эрүүл мэнд, спорт, үйлдвэрлэл, хог хаягдлын салбарын үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцов. | 92.5 | 95 |
| 54 | 4.2.1 . | **Арга хэмжээ-4.2.1.** Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлэн гадаад улс орон, хотуудтай харилцаа тогтоож, харилцан туршлага солилцоно. | - | Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ | 2 | 1 ба түүнээс дээш | Гадаад харилцааг өргөжүүлэх хүрээнд “Royal travel” аялал жуулчлалын компанитай дүүргээс хамтран ажиллах санамж бичиг байгуулав. Тус санамж бичгийн хүрээнд Солонгос улсад 6 сарын хугацаатай улирлын чанартай гэрээт ажилтан гаргахаар бүртгэлийг хийн, дүүргийн хэмжээнд 10 иргэн болзол, шаардлагыг ханган бүртгүүлээд байна. Мөн дүүргийн Засаг дарга Бүгд найрамдах Хятад ард улсын Бээжин, Ханжөү, Жяшин, Наньнин, Чиньжөү хотын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, туршлага судлах айлчлалыг 2023 оны 04 дүгээр сарын 20-28-ны өдрүүдэд хийлээ. БНХАУ-ын коммунист намын урилгаар 4 албан хаагч Бээжин хотын ХКН-ын залуучуудын эвлэлийн хорооны сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнд ажиллаж, хятад маягийн модернизмийн онол ба практик, технологи, интернэт сүлжээ, цахим платформын чиглэлээр тушлага судлан, шинэ залуу удирдах ажилтнуудыг дадлагажуулах сургалтад хамрагдан, сертификат гардан авав. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 10 | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллага ОУБ, ТББ, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран 20 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд нийт 10 байгууллагын 22 албан хаагч БНХАУ, БНСУ, ОХУ, Нидерланд улсад ажиллан, эрүүл мэнд, спорт, үйлдвэрлэл, хог хаягдлын салбарын үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцон, мэдлэг ур чадвараа дээшлүүлэв. Үүнд:<br>1. Дүүргийн Засаг дарга Бүгд найрамдах Хятад ард улсын Бээжин, Ханжөү, Жяшин, Наньнин, Чиньжөү хотын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, туршлага судлах айлчлалыг 2023 оны 04 дүгээр сарын 20-28-ны өдрүүдэд хийв.<br>2. БНХАУ-ын коммунист намын урилгаар 4 албан хаагч Бээжин хотын ХКН-ын залуучуудын эвлэлийн хорооны сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнд ажиллаж, хятад маягийн модернизмийн онол ба практик, технологи, интернэт сүлжээ, цахим платформын чиглэлээр тушлага судлан, шинэ залуу удирдах ажилтнуудыг дадлагажуулах сургалтад хамрагдан, сертификат гардан авав.<br>3. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Нидерландын Хаант улсын Гаагийн Академиас зохион байгуулсан “Засаглалыг бэхжүүлэх нь” сэдэвт семинарт 2023 оны 08 дугаар сарын 07-16-ны өдрүүдэд хамрагдав.<br>4. “Багахангай үйлдвэр технологийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | парк"-ийн захиргаа, инженерийн албаны 10 албан хаагч 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдөр БНХАУ-ын Шаньси Пиньяо Фэнгян Каол ба кокс группийн эрчим хүчний үйлдвэртэй танилцав.<br>5. Дүүргийн Эрүүл мэндийн төвийн 1 сувилагч БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод "Сувилагчийн ур чадварыг дээшлүүлэх сургалт"-д 2023 оны 10 дугаар сарын 15-21-ний өдрүүдэд хамрагдав.<br>6. Дүүргийн Эрүүл мэндийн төвийн хүүхдийн ахлах зэргийн 1 эмч Оросын холбооны улсад "Хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх" чиглэлээр зохион байгуулагдсан сургалтад 2023 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс 11 сарын 04-ний өдөр хүртэлх хугацаанд хамрагдлаа.<br>7. "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ-ын 1 албан хаагч 7 өдрийн хугацаанд БНСУ-ын Сөүл хотын хог хаягдал ногоон байгууламж, Хот тохижилтын үйл ажиллагаатай танилцав.<br>8. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын Зүүн хойд Азийн бүсийн төв, Дэлхийн боловсрол сургалтын төвөөс БНСУ-ын Инчеон хотноо зохион байгуулсан "Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйл ажиллагааг тусгаж хэрэгжүүлэх нь" сэдэвт сургалтад 2023 оны 11 дүгээр сарын 13-16-ны өдрүүдэд тус дүүргийн ИТХ-ын ажлын албаны дарга бөгөөд нарийн бичгийн дарга, ОБХ-ийн дарга нар тус тус хамрагдав.<br>9. Нийслэлийн биеийн тамир, спортын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | газар, БНСУ-ын Сөүл хотын Биеийн тамир, спортын газрын хамтын ажиллагааны хүрээнд Сөүл хотын Жүдо бөхийн холбооны урилгаар 2023 оны 11 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд харилцан туршлага солилцох "Seoul cup" арга хэмжээнд дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга оролцов.<br>Дүүргийн зүгээс Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Бугат хоттой хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд "Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг 9 чиглэлээр байгуулахаар төслийг боловсруулан, Хятад хэл рүү орчуулав. Уг санамж бичгийн төслийг НЗДТГ-т хянуулахаар хүргүүлээд байна.<br>Япон улсын зарим хоттой хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцаа холбоо тогтооход дэмжлэг үзүүлэх тухай дүүргийн Засаг даргын 2023.11.30-ны өдрийн 1/904 дүгээр албан бичгийг Япон дахь Улаанбаатар хотын төлөөлөгчид хүргүүлээд байна. Мөн гадаадад ажиллах хүчин зуучлах зорилгоор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч М.Баянцогтын санаачилгаар Бүгд Найрамдах Унгар улсын Будапешт хот дахь "HUNGARI MEAT" махны үйлдвэрт тус дүүргээс 10 иргэн 2 жилийн хугацаатай хөдөлмөрийн гэрээг байгуулан ажиллаж байна. Цаашид 7 иргэн тус үйлдвэрт ажиллахаар хүсэлтээ өгч, хөдөлмөрийн гэрээ байгуулах шатандаа байна. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 4 байгууллагаас олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт хамрагдах саналыг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүргүүлэн, 3 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд: ДЭМБ-аас Яаралтай тусламжийн багц 5 ш, Японы элчин сайдын яамны "Өвсний үндэс-хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж" хөтөлбөрийн хүрээнд 44 дүгээр цэцэрлэгийн харьяа "Алтай" бүлгийн их засварын ажил, Дээрет олон улсын байгууллагаас цүнх, хичээлийн хэрэгслийг олголоо. Мөн Японы "Хүүхдийг ивээх сан"-тай хамтран ажиллахаар хүсэлт хүргүүлэн, харилцан уулзалтуудыг зохион байгуулж, тоон судалгаа, холбогдох мэдээллүүдийг тус санд хүргүүлээд байна. | | |
| 55 | 4.2.2. | **Арга хэмжээ-4.2.2.** Гадаад арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлын тайлан, биелэлтийг холбогдох газарт хүргүүлэх | - | Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ | - | 1-ээс доошгүй | 2023 оны гадаад үйл ажиллагааны хагас болон жилийн эцсийн тайланг загвар маягтын дагуу гарган, НЗДТГ-ын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэст 4/535, 3/938 хүргүүлэв. | 100 | 100 |
| 4.3 | | **Зорилт 4.3.** Иргэдийн санал хүсэлтийг сонсон, үйл ажиллагаандаа тусгах | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | - | 90 | Удирдлагуудын иргэдтэй хийх уулзалт, Явуулын нэг цэгийн үйлчилгээг иргэдэд үзүүлэн, иргэдээс гаргасан санал хүсэлтийг шийдвэрлэн ажиллалаа. | 95 | 85 |
| 56 | 4.3.1. | **Арга хэмжээ-4.3.1.** "Явуулын нэг цэгийн үйлчилгээ"-ний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Орон нутгийн төсөв 1.2 | Явуулын үйлчилгээний й тоо | 2 | 2 | Дүүргийн Засаг даргын 2023 оны А/187 дугаар захирамжаар батлагдсан мэргэжлийн байгууллагын ажлын хэсэг дүүргийн төвөөс алслагдан оршин сууж буй мал бүхий иргэд, малчин айл өрхөд 2023 оны 09 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд "Явуулын нэг цэгийн үйлчилгээ"-г үзүүллээ. Нийт 15 төрлийн үйлчилгээг 49 өрхийн 63 иргэнд үзүүлж, 13 төрлийн 400 гаруй гарын авлага тараах материалыг иргэдэд олгов. Дүүргийн Жижиг, дунд үйлдвэр, | 90 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлчилгээг дэмжих төвөөс өрхийн үйлдвэр эрхлэгчдийн урласан олбог, эсгий таавчиг, монгол цамцыг иргэдэд танилцуулан, сурталчлав. Иргэдэд тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд 56 иргэнд тоон гарын үсэг олголоо. Мөн Засаг дарга дүүрэгт хийгдсэн онцлох ажил, цаашид хэрэгжүүлэх ажлын талаарх мэдээллийг иргэдэд өгч, 7 иргэнээс 11 хүсэлт гаргасан бөгөөд дүүргийн Засаг дарга, холбогдох мэргэжилтнүүд тайлбар, мэдээллийг уулзалтын үеэр өгөв. | | |
| 57 | 4.3.2. | **Арга хэмжээ-4.3.2.** "Иргэн таныг сонсьё" уулзалт зохион байгуулах | - | Уулзалтын тоо | 2 | 3 | Удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтын журам, хуваарийг дүүргийн Засаг даргын 2023 оны А/44 дүгээр захирамжаар шинэчлэн батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллав. 3-р улирлын байдлаар үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг иргэдэд танилцуулах, санал хүсэлт авах ажлын хүрээнд УИХ-ын гишүүдийн иргэдтэй хийх уулзалтыг 3 удаа, дүүргийн Засаг дарга болон удирдлагуудын иргэдтэй хийх уулзалтыг 3 удаа зохион байгуулж, 40 аж ахуйн нэгж, байгууллагын давхардсан тоогоор 800 гаруй иргэдтэй уулзаж, санал хүсэлтийг сонсов. Уулзалтаар 85 иргэнээс 148 санал хүсэлт гаргаж, холбогдох тайлбар, мэдээллийг уулзалтын үеэр өгч ажиллалаа. | 100 | 100 |
| | 4.4 | **Зорилт 4.4.** Төрийн байгууллагуудын үйлчилгээнд хэрэглэгчийн | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 91 | Төрийн байгууллагуудын үйлчилгээний талаар 2 төрлийн судалгааг авч, 141 | 90 | 70 |